

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-37

- 1. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 7-14
 - 2. Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 14-37
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
4 дүгээр сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 28 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Рэгдэл, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ж.Баясгалан, А.Ганбаатар, Т.Мөнхсайхан, М.Нарантуяа-Нара;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Бямбасүрэн.

Нэг.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн С.Отгонжаргал, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, мөн албаны зөвлөх П.Батчулуун, “Өөжин мед” үр шилжүүлэн суулгах эмнэлгийн эмч Г.Гэрэлцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баярбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Л.Энхнасан, Б.Бейсен нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, С.Эрдэнэбат, Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгах санал:

П.Ганзориг: 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж, мөн зүйлийн 6.2.1 дэх заалтын “гэрлэлтээ бүртгүүлснээс хойш 3-аас доошгүй жил” гэсний дараа “, бэлгийн эс шилжүүлэн суулгах тохиолдолд нэгээс доошгүй жил” гэж мөн заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “гадаад улсын иргэн,” гэсний дараа “харьяалалгүй хүн” гэж, мөн заалтын “эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж тус тус нэмж, мөн зүйлийн

6.2.1 дэх заалтын “тус улсад” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 4
Бүгд: 22
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14 дэх хэсэг нэмэх:

“15.13.Нэг донорын бэлгийн эсийг зөвхөн тухайн нэг гэр бүлд ашиглахыг зөвшөөрнө.

15.14.Үр хөврөлийг эцэг, эхээс нь бусад хүмүүст ашиглахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 22, 23 дугаар зүйлийг нэгтгэн 22 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл. Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж болон амьд донорт үзүүлэх дэмжлэг

22.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг эрүүл мэндийг дэмжих сангаас олгоно.

22.2.Амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд сувилуулах журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.3.Хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зарчмын зөрүүтэй 3 дугаар санал буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг эрүүл мэндийг дэмжих сангаас олгох санал дэмжигдсэнтэй холбогдуулан хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, мөн газрын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Л.Пүрэвдулам, Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Пүрэвсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн ажлын бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч С.Учрал, И-Монгол академи Улсын төсөвт үйлдвэрийн газрын Цахим засаглалын хэлтсийн төслийн менежер Б.Батзул, Хуульч, судлаач Г.Оюунболд, Судлаач Л.Долгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, төслийн талаарх Засгийн газрын саналыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир нар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, П.Наранбаяр, Д.Бум-Очир, Л.Энхнасан, Ж.Чинбүрэн, Ж.Галбадрах, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн ажлын бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч С.Учрал, Хуульч, судлаач Г.Оюунболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Х.Болормаа нар үг хэлэв.

П.Ганзориг: Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

П.Ганзориг: 1.Ахмад настны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Боловсролын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 49 минут үргэлжилж, 30 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

П.ГАНЗОРИГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 28 минут.

ХҮНҮЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Ганзориг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн ирж, ирц 56,7 хувьтай бүрдсэн тул Хүний хөгжил, нийгмийн бай бодлогын байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай, Аюушийн Ариунзаяа, Хөххүүгийн Болормаа, Дуламын Бум-Очир, Жанчивын Галбадрах, Пүрэвжавын Ганзориг, Даваасамбуугийн Ганмаа, Сархадын Зулпхар, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, Банзрагчийн Түвшин, Бадарчийн Хэрлэн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Лутаагийн Энхнасан, Доржзовдын Энхтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гишүүд хуралдаандаа хүрэлцэн ирж оролцож байна.

Байнгын хорооны өнөөдрийн хурлаар 2 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

2.Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсгээс Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Отгонжаргал Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн, Пандааны Батчулуун Эрхтэн, эд шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх, Баяраагийн Алтантулга Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга, Ганбатын Гэрэлцэцэг “Өөжин мэд” Үр шилжүүлэн суулгах эмнэлгийн эмч.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Б.Баярбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу зарчмын зөрүүтэй 4 санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй 4 саналыг гүйцээн боловсрууллаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

П.Ганзориг: Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.1.3-д заасны дагуу танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. 2 гишүүн байна. Ариунзаяа гишүүний микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Ажлын хэсгийнхэнд талархлаа дэвшүүлмээр байна. Өнгөрсөн чуулганы хэлэлцүүлгийн явцад бас санал гаргаж, түүнийг маань хүлээн авч, редакц найруулгаар гүйцээн боловсруулж, хаанаас тэтгэмж олгох вэ гэдэг асуудлыг маш тодорхой тусгаж өгч байгаад бас талархлаа дэвшүүлмээр байна.

Ер нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг Эрүүл мэндийг дэмжих сангаас яг энэ амьгүй донорын ар гэрт нь олгоно гэдэг энэ заалт маш чухал юм. Тэгээд яах вэ, миний санал Эрүүл мэндийг дэмжих сангаас 10 сая төгрөг гэж тодорхой мөнгөн дүнг зааж өгөхийг бас хүссэн санал гаргасан. Тэгээд Эрүүл мэндийн сайд Батшугартай бас ярилцаж, болно 10 сая төгрөгөөр нь байхад зөв байна гэж тухайн үедээ хэлэлцэж зөвшөөрсөн. Гэхдээ ажлын хэсгийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх гэдгээр нь хэвээр нь үлдээгээд, гэхдээ яах вэ, Эрүүл мэндийг дэмжих сан гэдгээр нь өөрчилж өгсөн байна. Тэгээд энд талархлаа дэвшүүлмээр байна. Ер нь яах вэ, нөгөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй аливаа асуудлуудыг уячихаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 жилд 1 удаа

нэмэгдүүлнэ гэдэг заалт нь өөрөө сайн дурын даатгалын шимтгэл, Эрүүл мэндийн даатгалын шимтгэл, НДШ эргээд нөгөө цалин хөлснөөс тооцогдох дээд хэмжээний хязгаар гэх зэрэг маш олон зүйлүүдтэй уялдаатай байдаг учраас энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй аливаа төлбөр болон бусад энэ тэтгэмж, тарифуудыг уяхгүй байя, салгая гэсэн ийм саналыг гаргаж байсан юм. Тэгэхээр уг нь бол 10 сая төгрөг гэж үнийн дүнгээрээ байсан их зүгээр байх байсан юм гэсэн ийм юутай байна.

Тэгээд тодруулж бас хэлэхэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх энэ оршуулгын тэтгэмжийг Эрүүл мэндийг дэмжих сангаас олгоод явах нь эргээд нөгөө НДШ төлсөн эсэхээс хамааруулж, тухайн нийгмийн даатгалаас ч юм уу, эсвэл эрүүл мэндийн сангаас ч юм уу олгож байсан энэ явдлыг нэг мөр тодорхой болгож зөвхөн Эрүүл мэндийг дэмжих сангаас олгох болсон нь илүү сайн, тодорхой болж өгч байгаа. Нийгмийн даатгалын сангаас олгодог оршуулгын тэтгэмж ердийн горимоороо нийгмийн даатгалын харилцаанд орсон хүмүүст ердийн хэмжээгээрээ олгогдоод хэвээрээ явагдана. Тэгэхээр энд бол аль нэгнээс давхардсан гэдэг тийм ойлголт байхгүй. Энэ амьгүй донорын тэтгэмж нь оршуулгын тэтгэмж нь тусдаа ингээд явж байгаа гэдгийг бас тодруулж хэлсэн нь зүйтэй байх гэж энэ үгийг авлаа. Баярлалаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Баярбаатар гишүүн хариулъя.

Б.Баярбаатар: Нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлгийн явцад бол хууль санаачлагч Ариунзаяа гишүүн бас сая гаргасан саналуудаа дурдлаа. Тэгээд 1 дүгээрт бол хуулийн төслийг анх өргөн барихад хууль санаачлагч бол 10 дахин нэмэгдүүлсэн гэдэг ийм томъёоллоор оруулж ирсэн. Ажлын хэсгийн явцад 1 өөрчлөгдөөд, буцаж энэ 10 дахин гэдгээр орсон.

Дараагийн 1 асуудал бол ийм байгаа юм. Өнөөдөр бол оршуулгын зардалд Нийгмийн даатгал төлдөг хүн бол 3 сая төгрөг, амьгүй донор болсон тохиолдолд Нийгмийн даатгалаас 4,5 сая төгрөг авч байгаа. Энэ бол ингээд цаашаа тэр оршуулгын зардалдаа бол 3 сая төгрөг бол авна. Амьгүй донор болсон ч байсан гэсэн. Дээр нь энийг ерөөсөө л нийгмийн даатгалтай холбох, уях нь буруу юм гэж үзээд, нөгөө Эрүүл мэндийг дэмжих сангаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн өнөөдрийн зардлаар тооцвол 7,5 сая, 8 сая орчим төгрөгийн асуудал, дээр нь 3 саяыг нэмэхээр нөгөө таны хэлээд байгаа 10 сая чинь бол ингээд даваад гараад явчхаж байгаа. Дараа нь бол энэ магадгүй хуулийг 5 жил тутамд үнэлгээ хийнэ. 5 жилийн дараа бол энэ асуудлаа эргээд харахад бол бас 10 сая төгрөг маань 5 жилийн дараах хэд болчих вэ гэдэг ийм нөхцөл байдал байсан учраас асуудлаа бол ингэж оруулж ирсэн. Санг нь бол тодорхой болгоод, тэгээд хууль дагаж гарч байгаа тогтоол дээр бас 2 сангийн хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулахаар тогтоолд тусгаад оруулж ирж байгаа гэдгийг л хэлье.

П.Ганзориг: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Тодруулаад дахиад хэлэхэд Нийгмийн даатгалын сангаас нийгмийн даатгалын харилцаанд орсон буюу НДШ төлчихсөн энэ харилцаанд орсон хүмүүст оршуулгын тэтгэмж олгогддог. Ахмад настны хувьд хэрэвзээ нийгмийн даатгалын сангийн харилцаанд ороогүй байх юм бол ахмад настнуудад халамжийн сангаас оршуулгын тэтгэмж бас олгогдох ийм боломж байдаг. Тэрнээс биш хөдөлмөрийн насны нийгмийн даатгалын харилцаанд ороогүй хүн байх юм бол оршуулгын тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас авдаггүй юм шүү гэдгийг энэ ташрамд бас хэлмээр байна.

Тэгээд мөн түүнчлэн өнөөдөр нийгмийн даатгалын салбар Монгол Улсад үүсэн хөгжсөний 84 жилийн ойн өдөр тохиож байгаа. Нийгмийн даатгалын салбарт ажиллаж байсан үе үеийн ахмадууд, нийгмийн даатгалын харилцаанд орсон үе үеийн шимтгэл төлөгч, тэтгэвэр авагч нарт нийгмийн даатгалын салбарын үүсэж хөгжсөний 84 жилийн ойн баярын мэндийг хүргэе. Баярлалаа.

П.Ганзориг: Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууя. Бейсен гишүүнийг асуулт дээр нэмчихье.

Л.Энхнасан: Энэ өдрийн мэндийг хүргэе. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хуулийг дэмжиж байгаа. Тэгээд энэ ажлын хэсэгт орж ажилласан. Харин энэ 22.1 дээр нөгөө эрхтэн, эд, эс суулгах, амьгүй донорыг дэмжих зорилгоор оршуулгын тэтгэмж олгох зохицуулалтыг тусгасан байгаа. Энэ ер нь бол хүний амь аврах тогтолцоог дэмжиж байгаа зөв чиглэл гэж үзэж байгаа. Харин 1 анхаарах юм нь болохоороо ер нь олон улсад бол донорын тогтолцоонд урамшуулал биш ийм хүмүүнлэгийн сайн дурын үндсэн дээр байдаг. Тэгээд би бол өчигдөр энэ зарчмын зөрүүтэй саналыг бол дэмжээгүй байгаа. Яагаад дэмжээгүй гэвэл Эрүүл мэндийг дэмжих сангаас гарах нь зүйтэй юу, үгүй юу гэдэг дээр эргэлзэж байна. Яагаад гэвэл сангийн зориулалт, зарцуулалтын хяналт нь илүү тодорхой болж байж эндээс гарах уу гэхээс яг одоо эрүүл мэндийн тухай хуулийг ингээд харах юм бол нийгмийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол, мэдээллийг олгох, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, тэгээд тусгай хөтөлбөрүүдийг дэмжих гэсэн эдгээр зориулалтаар бол Эрүүл мэндийг дэмжих сангаас гарах боломжтой байна. Тэгэхээр би Эрүүл мэндийн яамны хүмүүсээс асуумаар байна. Энэ сан нь тэтгэмж эсвэл нөхөн олговор гэхээр олгоход боломжтой юм уу. Энэ дээр Эрүүл мэндийн яам юу гэж бодож байгаа юм бэ.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гишүүн Эрдэнэбат гишүүн хариулъя.

С.Эрдэнэбат: Энэ талаар тодруулсан Энхнасан гишүүн ээ. Эрүүл мэндийг дэмжих санг хэрэгжүүлэх журам дотор оршуулгын тэтгэмж гэдэг заалт бол байна лээ. Тийм учраас бол одоо Их Хурлаас хууль батлагдсантай холбоотой дагах юун дээр энэ журамдаа тодорхой энэ хуульд заасан хэмжээг оруулж өг гэдэг байдлаар бол тусгачихад болох юм байна. Өөр сангуудыг тавихаар нийгмийн даатгал, ЭМД мөн ялгаа байхгүй. Даатгалын хуулийн үндсэн зарчим нь юу вэ гэхээр нөхөн төлөх ч гэдэг юм уу эсвэл огт даатгал төлж байгаагүй донор болох харилцааг даатгалын сан руу хажуугаас нь оруулж ирэхээр харин хуулийн зөрчилтэй болгоод магадгүй Нийгмийн даатгалын хууль, Эрүүл мэндийн даатгалын хуулиар олгох юм нь хуулийн зөрчилтэй учраас хасагдах магадлал байгаа учраас энийг тэр дэмжих сан нь бол өнөөдөртөө хамгийн боломжтой юм байна гэдгийг тодруулж асуусан.

Таны хэлдгээр яг хуульд байхгүй ч гэсэн журам дотор бол оршуулгын тэтгэмжийг олгох зардлын ангилал дотор оршуулгын тэтгэмж гэдэг бол байгаа юм байна лээ.

П.Ганзориг: Эрүүл мэндийн яамнаас нэмж хариулах уу. 5 номерын микрофон.

Н.Эрдэнэбаяр: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэнэбаяр. Энхнасан гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яамнаас ер нь гол баримталж байгаа зарчим бол амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах гэдэг энэ концепцыг бол хамгийн 1 дүгээрт нь бид нар баримталж ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл бид нар бодлого чиглэлээ бол

энэ дээрээ бас зориулж ажиллана. Яг бодит байдал дээр бас таны асууж байгаа бас нэлээн юутай байгаа. Өөрөөр хэлбэл Эрүүл мэндийг дэмжих сан дээр төвлөрч байгаа мөнгө маань яг нөгөө энэ санд хуримталж байгаа мөнгөний бас тодорхой хувь буюу 0.1 орчим хувь нь ер нь бол ирж байгаа. Тэгээд бид нар тусгай журмаар зохицуулж байгаа. Энэ дээр гадаадад эмчлэх шаардлагатай хүмүүсийн зардлыг шийдвэрлэх гэдэг юм уу бас олон улсын шинэ технологиудыг нэвтрүүлэх гээд олон зориулалтаар явж байгаа. Сүүлд бас нийгэмд гарсан асуудалтай холбоотой энэ дээр бас зохицуулалтууд үлдчихээд .../минут дуусав/

П.Ганзориг: Энхнасан гишүүн тодруулах уу. 5 номерын микрофон дээр нэмэлт минут.

Н.Эрдэнэбаяр: Энэ дээр яг сангийн зориулалт дээр бас оршуулгын тэтгэмж гээд бас оруулаад өгчихсөн байж байгаа. Тэгэхээр гишүүдээс гарсан саналын дагуу бид нар цаашдаа энэ сангийнхаа хуримтлалыг бас нэмэгдүүлж, зарцуулалтыг нь илүү бас яг тодорхой болгох дээр энэ хуулийн дараа бас тодорхой зохицуулалтуудыг хийнэ гэдэг байдлаар төлөвлөж ажиллаж байгаа юм.

П.Ганзориг: Энхнасан гишүүн тодруулъя.

Л.Энхнасан: Би бол энийг дэмжиж байгаа. Тэгэхдээ хамгийн гол нь санаа зовж байгаа юм болохоороо нөгөө өмнө бас асуудал гарсан чинь яг гол нь нөгөө яаман дээр холбогдох журам нь яг тухайн үед гараагүйгээс болоод, үл ойлголцол болсон учраас энэ дээр анхаарч яам ажиллаарай гэдэг дээр л хамгийн гол нь анхаараад байгаа шүү. Тэгээд яам журмаа бол нэн яаралтай өөрчлөөрэй.

П.Ганзориг: Бейсен гишүүн асууя.

Б.Бейсен: Энэ 4.1.2, 4.1.14, 4.1.16-д жишээлбэл өөр хүний хүүхэд тээж төрүүлээд өгч байгаа асуудал байна шүү дээ. Тэрний биологийн юуг тогтооходоо яаж шийдэх вэ. Биологийн эцэг эхийн тухай юуг. Энийг хуульчлах юм уу. Тийм асуудал зөндөө гарч байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт, тэр амьд донорын асуудал байж байна даа. Одоо зарим нь эрхтнээ худалдаж байна шүү дээ. Тэрний хэмжээг яаж тогтоох юм. Дараа нь тодруулъя.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Баярбаатар гишүүн хариулах уу. 4 номерын микрофон хариулъя.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн албаны дарга Алтантулга. Бейсен гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн төсөл дээр бид нар одоо мөрдөгдөж байгаа Донорын тухай хууль дээр амьд донорын нэр томъёоны тайлбарыг бол илүү өргөн хүрээтэй авч үзэж байгаа. Алба байгуулагдсанаас хойш өнөөдрийг хүртэл бол яг энэ гэр бүлийн гишүүдээс нь амьд донор сонгох ийм боломж байсан. Нэмээд яг хүргэн, бэрээс нь донор болох боломжтой мөртөө бусад яг гэр бүлийн гишүүдээс нь донор болох ямар ч боломжгүй энэ тохиолдлоос болж харамсалтайгаар амь нас нь эндэж байгаа ийм тохиолдлууд ч гэсэн бид нар дээр бүртгэгдэж байсан. Энэ ч үүднээсээ бид нар энэ шинэ хуулийн төсөлдөө эмчлүүлэгч нь амьд донороосоо авахын тулд эхлээд бол яг гэр бүлийн гишүүдээсээ, үнэхээр энэ хүрээндээ байхгүй байх юм бол дараагийн хүргэн, бэрээсээ сонгох боломжийг нь илүү нээж өгч байгаа гэсэн энэ тогтолцоог оруулж өгсөн.

Дараа нь бол энэ эсийн донор гэдэг нэр томъёоны тайлбар дээрээ бүр илүү тодорхойлсон. Энэ дээр яг бэлгийн эсийн донор, үүдэл эсийн доноруудын асуудлыг оруулсан. Биологийн эцэг эхийг тодорхойлох энэ асуудал яг одоо мөрдөгдөж байгаа холбогдох журам, хуулиараа бүрэн зохицуулагдаж байгаа. Тухайн биологийн эцэг эхийг тодруулъя гэх юм бол нэг хууль хяналтын байгууллага, нэг прокурорын зөвшөөрөлтэй биологийн эцэг эхийг холбогдох байгууллага нь генетикийн шинжилгээ хийж тодруулах ийм үүрэгтэй байгаа.

П.Ганзориг: Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Гол нь миний асууж байгаа юм нууц биш л дээ. Өөр хүний хүүхэд төрүүлж өгч байгаа асуудал байгаа. Тэгэхээр үүний эд эсийн тохиргоог яах юм. Бас хүний нууцлалтай холбоотой асуудал. Тээгч эх нь нууцаар яаж байгаа. Тэгээд эцгийг нь тодрууллаа гэхэд дараа нь тэр эхийн асуудалд дараа нь маргаан гарвал яаж шийдэх юм.

П.Ганзориг: 4 номерын микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Бейсен гишүүний асуултад нэмж хариулъя. Яг энэ тээгч эх дээр өнөөдрийн байдлаар үр шилжүүлэн суулгах 5 эрүүл мэндийн байгууллага үр шилжүүлэн суулгаж байгаа. Энэ дээр тээгч эх ашиглах тохиолдолд бол тухайн эмэгтэй маань ямар нэгэн тээж түрүүлэх боломжгүй нь тухайн холбогдох эрүүл мэндийн байгууллагын дүгнэлт гарсан тохиолдолд тээгч эхийг ашиглаж болно гэсэн энэ зохицуулалтыг оруулж өгсөн. Нэмэлтээр яг энэ тээгч эх, яг тухайн эмчлүүлэгчийн биологийн эцэг эхийн бүрдсэн үр хөврөлийг суулгах энэ тогтолцоо бүрэн ил тод, шилэн байдлаар манай Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах алба дээр нэгдсэн бүртгэл мэдээний сан ажиллаж байгаа. Энэ дээрээ бид нар илүү ил тод, шударга шилэн тогтолцоог бүрдүүлснээрээ илүү аюулгүй тогтолцоог бүрдүүлж чадна гэж бид нар харж байгаа.

П.Ганзориг: Бейсен гишүүн дахин тодруулъя.

Б.Бейсен: Тэр тээгч эх нь хүүхдээ тээчхээд, дараа нь тэр эцэг эхэд нь өгөхгүй асуудал бас гарсан. Ганц 2 тохиолдол байсан. Нөгөө талаар тэр нууцын зэрэглэлтэй жирэмслээд, хүүхэд төрүүлж өгөх гэж байгаа асуудал байж байгаа. Эрүүл мэндийн байгууллагаар яахгүйгээр. Тэгэхээр энийг яаж шийдэх юм.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Баярбаатар гишүүн хариулчих.

Б.Баярбаатар: Яах вэ, өнөөдөр хэлэлцэх асуудлын хүрээндээ бол бид нар гүйцээн боловсруулах чиглэл авсан 4 саналынхаа хүрээнд энэ асуудлаа ярина. Анхны хэлэлцүүлэг дээр бол таны асуултуудад хариулаад, магадгүй бас зарим нэг саналуудыг өөрчлөх, сүүлийн наад зүйл бол би буруу ойлгоогүй бол жоохон хууль бус юм л асуучих шиг боллоо доо.

2-т Энхнасан гишүүний асуулт дээр энэ Засгийн газрын тусгай сангийн хуулийн 19.1-ийг би уншаад өгье. Эрүүл мэндийг дэмжих сан нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх зайлшгүй

шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх болон амьгүй донорт оршуулгын тэтгэмж олгох зориулалттай байна.

П.Ганзориг: Ажлын хэсгээс Чинбүрэн гишүүн тодруулж хариулья.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр Бейсен гишүүн хэрвээ хууль бусаар хэн нэгэн эмэгтэйг ашиглаж хүүхдээ тээн төрүүлэх нь өөрөө эрх зүйн хувьд бол болохгүй. Энэ мөлжлөг, хүний мөлжлөг. Тийм учраас бид хуульдаа оруулж байгаа санаа бол гэр бүл нь өөрсдөө хүүхэд төрүүлэх боломжгүй гэдэг нь тогтоогдсон тохиолдолд тээгч эхтэй байж болох тухай ярьж байгаа байхгүй юу. Тийм учраас хэрвээ тийм далд байдлаар ингэж хийж байгаа бол энэ эрүүгийн хариуцлага хүлээх ёстой болж байгаа юм. Хүн мөлжиж байна гэсэн үг. Хүний мөлжлөг. Тийм учраас энийг бол манай Монгол Улсад хориглож байгаа гэж ойлгоорой.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын даргын гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. 4 саналтай. Санал тус бүрээр явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж, мөн зүйлийн 6.2.1 дэх заалтын “гэрлэлтээ бүртгүүлснээс хойш 3-аас доошгүй жил” гэсний дараа “, бэлгийн эс шилжүүлэн суулгах тохиолдолд нэгээс доошгүй жил” гэж мөн заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “гадаад улсын иргэн,” гэсний дараа “харьяалалгүй хүн” гэж, мөн заалтын “эрхтэн, эд” гэсний дараа “,эс” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 6.2.1 дэх заалтын “тус улсад” гэснийг хасах. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад нийт 22 гишүүн оролцсоноос 18 гишүүн дэмжиж, 81,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14 дэх хэсэг нэмэх:

“15.13.Нэг донорын бэлгийн эсийг зөвхөн тухайн нэг гэр бүлд ашиглахыг зөвшөөрнө.

15.14.Үр хөврөлийг эцэг, эхээс нь бусад хүмүүст ашиглахыг хориглоно.” Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 77,3 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 22, 23 дугаар зүйлийг нэгтгэн 22 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл. Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж болон амьд донорт үзүүлэх дэмжлэг

22.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг эрүүл мэндийг дэмжих сангаас олгоно.

22.2. Амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд сувилуулах журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.3. Хуульд заасан бусад.” Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, 72,7 хувиар дэмжигдлээ.

4. Зарчмын зөрүүтэй 3 дугаар санал буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг эрүүл мэндийг дэмжих сангаас олгох санал дэмжигдсэнтэй холбогдуулан хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 22 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар дэмжигдлээ.

Нийт хууль санаачлагчид болон ажлын хэсгийн гишүүд баярлалаа.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлгийг бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баярбаатар танилцуулна.

14.56 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцье.

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун танилцуулна.

О.Саранчулуун: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Та бүхэнд Нийгмийн ажлын тухай хуулийн төслийн танилцуулгыг 6 слайдад бэлдэж, товчхон мэдээлэл хүргэе.

Энэ хуулийн гол чухал өөрчлөлт нь бол 1 стандарт, 1 арга зүй, 1 хариуцлагын тогтолцоог бий болгохтой холбоотой ийм хуулийн төсөл байгаа. Яагаад 1 стандартыг ярьж байгаа вэ гэхээр олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Алсын хараа 2050, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн бодлогын баримт бичиг, Нийгмийн ажлын үйлчилгээг иргэдэд хүргэх, амьдралын чанарыг сайжруулах, хүний хөгжлийг дэмжих чиглэлээр олон заалтууд тусгасан байгаа. Гэхдээ бид нар энийгээ хэрэгжүүлэх, энэ үйл явцыг илүү нарийн тодотгох шаардлагатай болоод байгаа.

Өнөөдөр нийгмийн ажлын 2026 оны эхний улирлаар жишээлбэл, Монгол Улсад боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, нийгмийн халамж, нийгмийн хөгжил, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын салбар, хууль зүйн салбарт нийтдээ 3 мянга гаруй нийгмийн ажилтан ажиллаж байгаа. Тэдний 80 хувь нь төрийн албан хаагчид, 60 гаруй хувь нь нийгмийн ажилтнаар бакалавр биш өөр мэргэжлээр бакалавр эзэмшсэн ийм хүмүүс байгаад байгаа гэсэн үг. Мөн нөгөө талаасаа төрийн албаны ангилал зэрэглэл тухайн салбараас хамаараад ТЗ, ТҮМ, ТҮБД гээд өөр өөр ялгаатай байдаг учраас цалин хөлс, нийгмийн баталгаа, үйлчилгээний төрөл, хэлбэр, мэргэжлийн хувьд ахих, дэвших үйлчилгээний чанар, мөн үр дүн, түүнийг үнэлэх үнэлэмж, үнэ цэн нь харилцан адилгүй, ялгаатай байдалд орчхоод байгаа гэсэн үг. Тухайлбал жишээ аваад үзэхээр 2025 оны 1 сараас сум, хорооны нийгмийн ажилтан, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог Засгийн газраас тогтоогоод, 770 албан хаагч ТҮМ4 ангилал зэрэглэлээр одоо ажиллаж байгаа. Тэдгээрийн цалин жишээлбэл 1,3 сая төгрөгөөр тооцож байгаа гэсэн үг. Гэтэл өнөөдөр дахиад цаашаагаа нийгмийн ажилтны хэрэгцээ шаардлага байсаар байгаа. Гэтэл яг энэ салбар дээр буюу халамж, хөдөлмөрийн хэлтэст ажиллах нийгмийн ажилтнуудын цалингийн зэрэглэл нь ТЗ8, 9 гээд нөгөө цалингийн зэрэглэл нь бусад салбараасаа 60 хувь, тухайн салбарынхаа дунджаас 60 хувь бага болчихоод байгаа гэсэн үг. Энэ цалин бага болон хийж байгаа ажил, гүйцэтгэл, ажлын тайлан харилцан адилгүйгээс хамаараад энэ салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын дундаж ажиллах жил 3 жил байгаа. Шинэ орсон нийгмийн ажилтнуудын 60 хувь нь эхний 3 жил ажиллаад, ажлаасаа гардаг ийм байдалтай болчихоод байгаа гэсэн үг.

Энэ хуулийн төсөл тэгвэл ямар асуудлуудыг шийдэж байгаа вэ гэхээр бид нар товчхондоо бол 2 талт үндэсний хороо, нөгөө талдаа нийгмийн ажлын мэргэжилтний холбоо гэдгийг байгуулаад, тэр холбоотойгоо Засгийн газар, холбоо 2 дундаа 2 талт үндэсний хороо гэдэг бүтцээр эдгээр асуудлуудыг зөвшилцөх ийм бүтцийг энэхүү хуулиар зураглаж оруулж ирж байгаа юм. Уг хуулийн төсөл нь 2023 оноос Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр анхны хувилбар танилцуулагдаж боловсруулагдаад, сайжруулаад бид нар энэ шинэчилсэн хувилбарыг бас танилцуулж байгаа гэдгийг бас хэлье.

Нийгмийн ажлын үйлчилгээний талаар тоо баримт дэлгэц дээр та хэдэд бол харагдаж байгаа. Өнөөдөр хүчинтэй байгаа 13 хууль, 162 заалтад 20 гаруй журмаар өнөөдөр нийгмийн ажлын үйлчилгээ хүрч байгаа. Нийгмийн хамгаалал, халамжийн нийт үйлчилгээний 80 гаруй хувь нь мөнгөн хэлбэртэй тусламж дэмжлэг байгаад байгаа. Тэдгээрийг нийгмийн ажилтнуудаар дамжиж үйлчилгээ үзүүлж байгаа. Олон улсад яадаг вэ гэхээр төрийн аливаа үйлчилгээг иргэнд хүргэхдээ лиценз юм уу зөвшөөрөл энэ тэр аваад хүргэдэг эмч гэж мэргэжил байна. Сувилагч, хуульчид байна. Мөн 1 нь бол нийгмийн ажил байгаа. Ер нь бид нар алсдаа энэ өөр өөр салбарт, өөр өөр тушаалаар, өөр өөр бүтцээр ажиллаж байгаа энэ нийгмийн ажилтнуудынхаа олон улсад зүй ёсоор хүргэж ирсэн олон улсын стандартынхаа дагуу үйлчилгээг нь цэгцлэх ийм шаардлага тавигдаад байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ хуулийн төслийн 6-18 дугаар зүйл дээр нийгмийн ажил гэж юу вэ, юуг нийгмийн ажил гэж ойлгох вэ гэдгийг нэлээн сайн тодорхойлж өгсөн байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бусад хуульд нийгмийн ажлын үйлчилгээний тодорхойлолт илүү тодорхой болно гэсэн үг. Тэгэхгүй бол өнөөдөр нийгмийн ажилтнууд бол янз бүрийн төрлийн ажлууд хийдэг. Заримдаа бол нарийн бичиг ч юм шиг, заримдаа байгууллагын хүлээн авагч ч юм шиг. Ерөөсөө ийм тогтсон нэгдсэн стандарт, арга зүй байхгүй учраас эргүүлээд тайлан нь ч гэсэндээ бас

нэгдсэн стандарт, арга зүйгүй болчхоод байгаа нь өөрөө энэ хуулийн бас 1 чухал шаардлага байгаа.

Нөгөө талд энэ 4 өөр салбарын зохицуулалтынх нь журам нь хоорондоо бас харилцан адилгүй байгаад байгаа. Тэгэхээр үүний үр дүнд ямар асуудал гарч байгаа вэ гэхээр энд нийгмийн ажлын үйлчилгээний ихэнх төрлүүд бол ер нь тэр хариу арга хэмжээний хэлбэртэй байгаа буюу хүчирхийллийн үед хүүхэд хамгааллын салбарт тухайн кэйс хэрэг тохиолдсон тохиолдолд нийгмийн ажилтан яаж ажиллах вэ гэдгийг заасан болохоос биш нийгмийн ажлын бусад функцүүд болох хүмүүсийг чадваржуулах, зөвлөгөө өгөх, сургах зэрэг функцүүд бол маш бүдэг тусгагдсан байгаа. Хэрвээ тусгагдсан байгаа тохиолдолд түүнтэй холбоотой бусад зайлшгүй хэрэгцээтэй орчин бүрдүүлэх ч юм уу, тэр зүйлүүд бол одоогийн энэ 162 заалт нь байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэр 20 гаруй төрлийн журамдаа ч гэсэн ялгаагүй байна гэсэн үг. Тэгэхээр энэ хууль дээр бид нар эхлэлтэй, төгсгөлтэй, эргээд үнэлгээтэй байдаг тэр нь баримталж байдаг ийм нийгмийн халамж хамгааллын үйлчилгээний тухай, үйлчилгээг нь илүү цэгцтэй болгож зааг ялгааг нь гаргаж өгч байгаагаар бас нэг онцлог байгаа гэсэн үг.

Халамжийн үйлчилгээ өнөөдөр 480-аад тэрбум төгрөг өнөөдөр Монгол улс халамжид зарцуулж байна гэсэн ийм тоо байдаг. Жил болгон бид нар халамжийн тухай асуудал ярьдаг. Бид нар бүр халамжаас хөдөлмөрт гэдэг ийм уриатай явдаг. Халамж авч байгаа хүн дотор янз бүрийн хүмүүс байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, боловсрол, мэргэжил эзэмшиж чадаагүй хүмүүс, эрүүл мэндийн асуудалтай, олон хүүхэдтэй гээд. Тэгэхдээ ер нь бол хөдөлмөрт шилжихийн тулд хүнд тухайн амьдралынх нь тодорхой үйл явдал юм уу, өвчин эмгэг ч байдаг юм уу амьдралын хүнд хэцүү үйл явдлынх нь дараа эргэж хөл дээрээ босоод өөрийгөө сэтгэл зүй болоод нийгмийн хувьд сэргээж засаж авчхаад ажилд орох ийм сэтгэл зүйн хэрэгтэй байгаа. Тэр хэсэг өнөөдөр юу ч байхгүй хоосон зай болоод байгаа байхгүй юу. Жишээлбэл гэмтлийн эмнэлэгт осол гэмтэлд орж гэмтсэн хүн байлаа гэхэд яаж эргэж өөрийнхөө амьдралаа буцааж авах вэ гэдэг дээр бол эрүүл мэндийн нийгмийн ажилтан ажилладаг гэсэн үг.

Тэгэхээр энэ зааг ялгаанд асуудал нь шийдэгдэхгүй байгаа учраас энэ зан үйлийн өөрчлөлт, энэ хувь хүний хөгжлийн асуудал нь дутагдалтай байгаа учраас өнөөдөр халамжаас хөдөлмөрт гэдэг энэ уриа маань лоозон хэлбэртэй болчхоод яг үнэндээ бас дутагдалтай байна гэдэг ийм дүгнэлтүүдийг бол нийгмийн ажилтнууд хийдэг. Тийм учраас энэхүү хуулийн 1 чухал зүйл бол салбар дундын уялдаа холбоо байгаа буюу мэдээллийн сан гэдэг зохицуулалт байгаа. Одоо төрийн үйлчилгээний Хур систем, Дан систем, и-халамж, нөгөө талд эрүүл мэндийн бүх мэдээллийн системүүд бол нэгдсэн сан руу шилжиж бид нар өгөгдлийг нэг тал руу салбар салбарт цуглуулж байгаа. Гэтэл яагаад өнөөдөр нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сангаас зарцуулж байгаа мөнгөний дүн зөвхөн мөнгөн хэлбэрээр тайланд ороод, нөгөө хүн нь мөнгө аваад сайжирсан юм уу, ажилд ордог болсон юм уу, одоо жишээлбэл ял эдэлсний дараа эргээд хүмүүжигч нийгмийн амьдралд гарахдаа ямар үйлчилгээ авсан юм ч гэдэг юм уу. Энэ зүйлүүд бол мэдээллийн санд бол байхгүй. Зөвхөн мөнгөн тайлангууд нь яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бид нар яг бодитоор Монгол Улсад халамж, хамгааллын үйлчилгээнийхээ чанарыг эргэж харах цаг болсон гэдгийг энэ хууль бас дахин сануулж байгаа. Мөн энэ хуулиараа мэдээллийн сан гэдэг бүлэг оруулаад энэ дээр шийдвэрлэнэ гэсэн ийм зохицуулалтыг хийсэн байгаа.

Бас нэг чухал зүйл нь юу вэ гэхээр энэ хууль дээр та бүхэнд тараагдсан материал дээр бол улсын төсөвт эзлэх ачааллын тухай тооцоо явсан байгаа. Энэ дээр бол анхны тухайн үед Нийгмийн ажлын хуулийг шинээр бий болгож, нийгмийн ажилтнуудыг сурахтай холбоотой хуулийн материал дээр үндэслэж хийсэн тооцоо байгааг бид нар Засгийн газраас ирүүлсэн саналын дагуу засварлаж, шинэчилсэн төсвийн тооцоонуудыг бас гаргасан. Энд шинэчилсэн төсөв дээр бол улсын төсөвт 920 сая төгрөгийн эхний хөрөнгө оруулалт хийж, энэ хөрөнгө оруулалтаараа мэдээллийн сан одоо байгаа өгөгдөл мэдээллийн санг цэгцлэх асуудал тусгагдсан байгаа. Нөгөө талд болохоор мэргэжлийн холбоо байгуулах эх үүсвэрийг бүрдүүлэх асуудал байгаа. Тэгээд 2 тал Үндэсний хороогоо бэхжүүлэх ийм ажлын төсөв тусгагдсан байгаа учраас та бүхэн энэ төсөв дээр бас хэрвээ тодруулах хэрэгтэй бол мэдээллийг энэ дээр бас хараарай гэж хүсэж байгаа юм.

Ер нь бол өнөөдөр манай энэ хуулийн оролцогч талууд энэ хуулийн төсөл бол зөвхөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын хүрээ биш. Энд Боловсролын яам, эрүүл мэндийн яам, Цахим яамны хүртэл оролцоотой ийм тогтолцоог бид нар өнөөдөр ярьж байгаа. Тэгэхээр та бүхэн асуулт тодруулах зүйл байвал бас өргөтгөсөн энэ бүрэлдэхүүн маань ингээд мэдээлэл өгнө.

Тэгээд Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэхүү хуулийг хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжиж өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Пүрэвдулам, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Туяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн ажлын бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч Учрал, Цогзолмаа Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, Пүрэвсайхан Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Оюунболд Хуульч, судлаач, Энхтулга Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Салбар дундын зохицуулалт Хариуцсан шинжээч, Батзул И-Монголиа Академийн Цахим засаглалын хэлтсийн төслийн менежер, Долгор Судлаач.

Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасны дагуу хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн танилцуулна гэж заасны дагуу Засгийн газраас төлөөлөөд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир Засгийн газрын дүгнэлтийг танилцуулна.

Т.Аубакир: Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм хүндэт гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсад анх удаа Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хурлаар хэлэлцэж байгаа өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын хүн ам 2024 оны тооллогоор 3.544.800-д хүрсэн бөгөөд хүн амын бүтэц нийгмийн хэрэглээний өөрчлөлт нь нийгмийн хамгааллын үйлчилгээний

ачааллыг эрс нэмэгдүүлж байна. Хүн амын бүлгээр авч үзвэл нийт хүн амын 36,2 хувийг 0-17 насны хүүхэд, 11,5 хувийг ахмад настан, 3,3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус тус эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд хотжилт, шилжин суурьшилтын тоо эрс нэмэгдэж, нийслэл хотын хүн ам 1 сая 800 мянгад, нийт өрхийн 69,3 хувь нь Улаанбаатар хотод төвлөрөн, эдийн засаг, нийгмийн байдал идэвхжихийн хэрээр иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах эрх зөрчигдөж, ялангуяа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг хамгаалал, анхаарал онцгой шаардлагатай иргэдийн амьдралын чанарт үзүүлэх сөрөг нөлөө нэмэгдсээр байна. Нийгмийн эдгээр өөрчлөлтийг эрсдэл багатай даван туулах, хамгаалалт шаардлагатай хүүхэд, иргэдийн амьдралын сайн сайхан байдлыг дэмжих хувь хүний чадамжийг хөгжүүлэх, нийгэмшүүлэх, сэргээн засах болон дахин эрсдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цогц үйлчилгээг нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг билээ.

Хүүхэд, гэр бүлийн хамгааллын салбарын статистик мэдээллээс үзэхэд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хамгаалалт шаардлагатай хүүхдийн тоо жилээс жилд өсөж байгаа боловч үйлчилгээний хүрэлцээ, хүртээмж сул байна. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага жил бүр 10 мянгаас дээш тохиолдол бүртгэгдэг ч хохирогчид үзүүлэх урт хугацааны нийгмийн ажлын үйлчилгээ хангалтгүй байсаар байна.

Монгол Улсад нийгмийн ажлын чиглэлээр их, дээд сургуульд суралцан төгсөгчдийн тоо 6000 гаруй хэдий ч одоо ажиллаж байгаа 5 мянга орчим нийгмийн ажилтан ердөө 40 орчим хувь нь мэргэжлийн нийгмийн ажилтан байгаа юм. Олон улсын туршлагаас харахад тухайлбал олон улсын нийгмийн ажлын холбоо нь зөвлөмж, холбооны зөвлөмжид 1 нийгмийн ажилтанд ноогдох хүн амын тоо 1000-1500 байхаар тогтоогдсон бол манай улсад нэг нийгмийн ажилтанд 3000-5000 иргэн ноогдож байна. Олон Улсын жишгээс 2-3 дахин өндөр үзүүлэлттэй байгаа юм.

НҮБ-ын хүүхдийн сангийн судалгаагаар нийгмийн ажлын үйлчилгээ сайн хөгжсөн улс орнуудад хүүхэд хамгааллын эрсдэл 20-40 хувиар буурдаг. Мөн Дэлхийн банкны тайланд дурдсанаар нийгмийн ажлын үйлчилгээ нь халамжийн зардлыг 10-20 хувиар бууруулах боломжтойг судлан тогтоосон. Эдгээр нөхцөл байдлаас үүдэн Монгол Улсад анх удаа Нийгмийн ажлын тухай бие даасан хуулийн төслийг боловсруулан өргөн барьж байгаа нь нийгмийн хамгааллын салбарт дараах шинэчлэлийг хэрэгжүүлэх суурь болно гэж салбарын мэргэжилтнүүд үзэж байна.

1 дүгээрт нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааг хуульчлан стандарт ёс зүй, хариуцлагын зохицуулалтыг бий болгох.

2 дугаарт нийгмийн ажилтны мэргэжлийн зэрэглэл, сурч хөгжих, нарийсаж мэргэших, карьер ахих боломжийг сайжруулж, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгааг тодорхой болгож, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана.

3-д салбар бүрийн нийгмийн ажилтны ялангуяа анхан шатад ажиллаж байгаа нийгмийн ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлж, хүн амд ноогдох нормативыг тогтоох зэрэг эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

4 дүгээрт нийгмийн ажлын үйлчилгээний төрөл, зохион байгуулалтыг тодорхой болгосноор төрийн болон төрийн бус байгууллагын түншлэлийг өргөжүүлнэ.

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагуудын оролцоо нэмэгдэх юм.

5 дугаарт үйлчилгээний чанар үр дүнд суурилсан хяналт, үнэлгээний тогтолцоог бий болгож нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлнэ.

Эцэст нь дүгнэн хэлэхэд энэ хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн ажлын үйлчилгээний хамрах хүрээ нэмэгдэж, эрсдэлт бүлгийн иргэдэд хүртээмжтэй чанартай мэргэжлийн үйлчилгээг хүргэх, урьдчилан сэргийлэх, шуурхай тусламж үзүүлэх, эрсдэлийг эрт илрүүлэх тогтолцоо бэхжих, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд нийгмийн ажлын оролцоо системтэйгээр хангагдана гэж үзэж байна.

Иймд Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Ганзориг: Хуулийн төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зулпхар гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Аубакир сайд аа, та нэг ийм юм яаман дээрээ бас шалгаад хараад өгөөч. Би 2020-2022 онд сайдаар ажилласан шүү дээ. Тэгээд ковидын үе байж таарсан. Тэгээд яг энэ цаг үед ковидын үед гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл ч гэсэн эрс нэмэгдсэн. Тэгээд олон улсын хамтын ажиллагааны зүгээс НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Японы Засгийн газар буцалтгүй тусламжаар манайд уг нь энэ нийгмийн ажилтны системийг нийлүүлж боловсруулж өгсөн байхгүй юу. Тэгээд 1000 таблет хүртэл өгч байсан. Манай Зуки сайд ч гэсэн байна. Бид нар тухайн үедээ бүх Монгол Улс даяар нийгмийн ажилтнууддаа яг энэ хамтарсан баг болоод, нийгмийн ажилтнууддаа 1100 гаруй таблет тарааж, яг энэ нам системийг уг нь оруулж байсан юм. Тэгээд ашиглалтад оруулж байсан. Тэгээд энэ нам систем буюу нийгмийн ажилтны мэдээллийн систем нь өөрөө ямар ач холбогдолтой юм бэ гэхээр тухайн хүчирхийлэлд өртөж байгаа эсвэл эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл, хүүхдийн мэдээллийг газрын зурагтай нь, бүр кэйсүүдтэй нь бид нар чинь нөгөө кэйс үүсгэж явдаг шүү дээ аливаа асуудал дээр нь. Тэгэхээр энэ кэйсүүдийг цаасаар нь биш яг цахим системд байршуулаад, тэгээд тухайн сайд жишээлбэл өөрийнхөө таблет дээр гэдэг юм уу, өөрийнхөө гар утсан дээр газрын зургаар хаана, Монгол Улсын аль өнцөгт хамгийн их тохиолдол гараад байна, хаана ямар өрхөд хамгийн их эрсдэлтэй байгаад байна вэ гэдгийг харах боломжтой байх ийм системийг уг нь бэлэн болгосон юм. Тэгээд одоо энэ систем маань ер нь байна уу, байхгүй юу. Нөгөө өгсөн таблетууд маань байна уу, байхгүй юу гэдэг ийм сонин асуудал. Хайран мөнгө. Буцалтгүй тусламжаар мэдээллийн системийг бий болгоод хамгийн гол нь бид нар аливаа асуудал болсон хойно нь биш, урьдчилж харж тухайн хүүхдүүдийг болон эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртөж байгаа хүмүүсийг хамгаалах л үүргийг төр хүлээдэг шүү дээ. Тэгэхээр ийм нийгмийн ажилтны мэдээллийн системийн асуудал уг нь хийсэн юм. Тэгээд гэр бүлийн агентлаг дээр хариуцагдаад, тэгээд сүүлдээ байхгүй болсон уу, яасан. Энийг та нэг шалгаж үзээрэй.

Нийгмийн ажилтны хууль өөрөө ямар ач холбогдолтой юм бэ гэхээр нийгмийн ажилтан гэдэг чинь өөрөө мэргэжил юм шүү. Тэрнээс биш зүгээр 1 орон тоон дээр хэн нэгэн хүнийг хэн нэгэн дарга, захирал өөрийнхөө туслах мэтээр ажиллуулах ийм орон тоо биш юм. Нийгмийн ажилтнаар сурдаг юм. Тэгэхээр энэ нийгмийн ажил гэдэг чинь өөрөө яг иргэдэд, хүүхдүүдэд, ахмадуудад, хөгжлийн бэрхшээлтэй

иргэдэд туслалцаа шаардлагатай байгаа хүнд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх нийгмийн ажилтан юм шүү гэдэг л ийм ухагдахуунаар боловсруулагдсан ийм хууль байгаа юм. Тэгэхээр ямар нэгэн нэмэлт зардал гарна гэж та бүхэн ойлгож болохгүй юм. Зүгээр эхний ээлждээ мэргэжлийнх нь хувьд хүлээн зөвшөөрсөн .../минут дуусав/

П.Ганзориг: Хууль санаачлагч Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Тийм ээ, баярлалаа. Яг одоо жишээлбэл хороо, халамж 6 төрлийн нийгмийн ажил байгаа юм л даа. Тэгээд 6 өөр ажлын байрны тодорхойлолттой. 6 өөр тайлантай. 6 өөр нөхцөл байдлын үнэлгээтэй болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд бид нар тэр дээр чинь яг 4 жил бакалаврт сурсан оюутнууд маань өнөөдөр ажил дээр гараад багшаа таны заасан тэр нөхцөл байдлын үнэлгээ, тэр үйлчилгээгээ чинь амьдрал дээр бид нар хийхэд манай ажлаас өгч байгаа ажлын байрны тодорхойлолт, заавар, тэр тайлан ерөөсөө болохгүй байна шүү дээ. Бид нар энэ зааснаар хэрвээ ажиллахгүй юм бол энэ салбартаа ажиллаад яах юм бэ. Өөр мэргэжлээр суръя гэдэг ийм л яриаг төгсөгчид маань өнөөдөр ярьж байгаа байхгүй юу.

Тэгэхээр хамгийн жижигхэн нэг жишээ жишээлье л дээ. Хүн ингээд хорт хавдраар өвдөөд, эмнэлгээс гарлаа. Эдгэлээ. Амь нас нь аврагдаад ямар ч байсан үлдлээ. Гэхдээ дараагийн удаа тэр хүнд юу хэрэгтэй гэхээр дахиж өвдөхгүйн тулд эрүүл мэндийн ямар зөвлөгөө хэрэгтэй гэхээр хоол, нойр, орчин. Дээрээс нь хорт хавдраа хүлээн зөвшөөрөх чинь өөрөө тухайн хүний сэтгэл зүйн процесс биш байхгүй юу. Тухайн хүний эхнэр нөхөр, гэр бүл нь өөрөө бас нэг өөр өөр үе шаттай процесс байгаад байгаа. Тэрийг хэн хийж байна гээч эрүүл мэндийн салбарт байгаа нөгөө эмнэлгээс гарахад нь ажилладаг нийгмийн дэмжих хэсэг байдаг юм уу, үйлчлүүлэгчийг дэмжих албаны нийгмийн ажилтан хийдэг байхгүй юу. Хэрвээ энийг тэр эмнэлгийн дарга, удирдлага ойлгоод ажлын байрны энэ хууль дээр байгаа тодорхойлолтыг аваад энэ чинь ийм процесстой юм байна шүү гээд явчих юм бол нийгмийн ажилтнууд яг л олон улсад ямар стандарт юмаар хийдэг вэ тэр лүүгээ л ер нь дөхөх юм байгаа юм. Тэгэхээр энийг нь ялгаж салгаж тодорхойлж өгч байгаад тэр мэргэжлээрээ ажиллах орон зайг нь бий болгож өгөхгүй бол өнөөдөр энэ мэргэжлийн яг мэргэжлийн үйлчилгээний орон зай нь хумигдаад байгаа гэсэн үг байхгүй юу. Бага багаар хумигдаад, хумигдаад сүүлдээ энэ дээр орох хэчнээн энийг эрэлттэй мэргэжил болгож зарлаад ч ажил олгогч нар нь ойлгохгүй, ажлын байран дээр хүлээж авахгүй бол энэ дээр хүүхдүүд ерөөсөө сурахгүй гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ орон зайг нь бий болгож өгөхийн тулд энэ хуулийн тэр 6-18 дугаар зүйл заалт бол шууд нийгмийн ажил гэж юу юм. Одоо зөвлөгөө нэрээр нийгмийн үйлчилгээний мөнгөнүүдийг хэрвээ харах юм бол зөвлөгөө гээд биччихсэн байгаа. Ард нь ямар зөвлөгөө өгсөн юм. Хэн өгсөн юм. Дэмжих бүлгийн зөвлөгөө өгсөн юм уу. Тэр хүн яаж өөрчлөгдсөн юм гэдэг процесс нь хаана ч тайлагнадаггүй. Хаана ч гардаггүй. Тэгээд л эргээд буцаад нөгөө халамж хамгааллын зардал дотроо багцаараа орж ирээд байгаа учраас энийг л ялгаж салгаад байгаа шүү гэдгийг хэлье. Тэгээд маш олон гишүүд бас дэмжиж байгаад их баярлалаа.

П.Ганзориг: Энэ төхөөрөмж бас дэлгэцийн нууцлалтай холбоотой хуулга наачихсан. Тэгээд хүчтэй дарахгүй бол нэрс бас орохгүй байгаа юм байна. Тэгээд асуулт асуух гишүүдийн нэрс дээр Галбадрах гишүүн, Чинбүрэн гишүүн 2-ыг нэмээд оруулъя. Дараагийн гишүүн Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Байнгын хорооны гишүүд, Байнгын хорооны дарга, ажлын хэсгийнхний өдрийн амгаланг айлтгая. Би хууль санаачлагчдын 1.

2 дугаарт энэ хуулийг бас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд анх боловсруулж байхад дэд ажлын хэсэг нь ахалж байсан ийм хүний хувьд энэ хууль бол зайлшгүй хэрэгтэй гэдгийг нэн түрүүнд бас та бүхэнд дуулгамаар байна.

Үүнээс энэ 30 гаруй жилийн өмнө энэ нийгмийн ажил Монголд бол өнөөдрийн утгаараа нэвтэрч эхэлсэн. Өнөөдөр 14 хууль, 30 орчим ийм журам болон стандартаар зохицуулагдсан ийм харилцаа явж байгаа. Тогтолцоо байгаа гэсэн үг. Гэхдээ тогтолцоонд байгаа боловч нэгдмэл ийм эрх зүйн орчин байхгүй ийм л зүйл байгаа. Тэгэхээр бидний энэ хуулийн гол зорилго бол энэ тогтолцоонд бий болчихсон зүйлийг эрх зүйн орчинтой болгож байгаа талаасаа бол онцгой ач холбогдолтой шүү гэдгийг хэлье.

Сая хэлж байна. Халамж, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсролын энэ салбаруудад бүгдэд нь нийгмийн ажлын тодорхой үйлчилгээнүүд нэвтэрчихсэн. Тэр битгий хэл шүүхийн шийдвэр биелүүлэх үйл ажиллагаанд ч гэсэн нийгмийн ажил байж байгаа. Цаашдаа ч гэсэн энэ бол өргөжих ийм чиг хандлагатай байгаа. Тэгэхээр ийм чиг хандлагатай байгаа үед нь бол эрх зүйн нэгдмэл орчингүй байлгах нь өөрөө энэ тогтолцоог цааш нь мэргэжлийн түвшинд бид удирдаад явах боломжийг бол хязгаарлаад байгаа юм. Яагаад гэхээр зэрэг салангид салангид ийм удирдлагатай. Яах вэ, тухайн салбарынхаа онцлогоос шалтгаалсан байдлаар тэнд бол үндсэндээ санхүүгийн болон хүний нөөцийн удирдлага хийгдэж байгаа. Гэхдээ хөгжлийнх нь буюу хүний нөөцийн хөгжлийн удирдлага бол огт хийгддэггүй. Мэргэжлийн удирдлага байхгүй гэж байгаа юм.

Та бүхэн мэргэшсэн нягтлан бодогчдын асуудлыг бол мэдэж байгаа байх. Үндэсний хэмжээнд нэгдсэн өөрийн гэсэн мэргэжлийн удирдлагатай шүү дээ. Тэгж байж энэ мэргэшсэн нягтлан бодох бүртгэл энэ чиглэлийн жишээ нь институт өөрөө бэхжээд явж байгаа ийм маш тодорхой туршлага бол бий. Тэгэхээр энийг энэ хуулиар бидний шинэ санаачилж байгаа, Саранчулуун гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийн гишүүдийн санаачилсан энэ хуулиар бол мэргэжлийн удирдлагатай болох чиглэлээр өөрийнх нь төрийн бус байгууллагад нь эрхийг нь олгосон бас шинэ туршлага юм байгаа юм. Төрийн зарим чиг үүргийг төсрийн бус байгууллагад шилжүүлж байгаа том туршлагыг хуульчилж байгаа бас хэлбэр. Сайн үр дүнгүүд гарч байгаа. Тэр дээр суурилсан байдлаар энэ хуульд бол онцгойлон тусгагдсан. Үйлчилгээний төрөл хэлбэрийг бол нарийвчлан зааж өгөхөөс гадна, тэрэнтэй холбоотойгоор жишээ нь үйлчилгээ үзүүлэхтэй уялдсан байдлаар нийгмийн ажилтнуудын өөрсдийнх нь эрх зүйн орчин, цаашлаад нийгмийн баталгааг хангах ийм хууль байгаа шүү гэж байгаа юм.

Нийгмийн ажилтнууд өнгөрсөн бараг 10 гаруй жил энэ хуулийг санаачилгаас нь авхуулаад тухайн үед бас л төрийн захиргааны байгууллага дээр яригдаж байсан. Байнга энэ хуулийг та бүхэн оруулаад батлаад өгөөч ээ гэдэг ийм хүсэлт явж байсан. Энэ зөвхөн ажилтнуудын асуудал бол биш. Бүхэлдээ тогтолцоог илүү бид боловсронгуй болгоод цаашаа аваад явах ийм нөхцөл шүү. Ингээд та бүхэн дэмжиж өгөөрэй гэдэг ийм хүсэлт байна. Баярлалаа.

П.Ганзориг: Үг хэллээ. Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ хуулийн ач холбогдлыг ойлгож байгаа. Хэлэлцэх эсэхийг бол дэмжинэ. Энэ хэрэгтэй хууль оруулж ирсэн байна. Яах вэ, энэ дээр бас техникийн шинжтэй зарим нэгэн саналууд, асуултууд байгаад байна л даа.

2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд оруулж ирсэн саналууд, өөрөөр хэлбэл энэ хууль санаачлагчид хэлж байсан саналуудыг уншиж байхад хамгийн гол нь ингээд байна л даа. Энэ жил бүр 96,5-160 тэрбум төгрөг энэ хуулийн төсөлтэй холбоотойгоор бол шаардана. Анхны хөрөнгө оруулалт нь 0,8 тэрбум гэж байна. Тэгээд сая эдийн засгийн тооцоог сүүлд тараасан энийг нь харахаар 0,9 тэрбум болгосон байна. Тэгэхээр энэ нэмэлт санхүүжилтийг яах вэ. Энэ бас нэлээн серьёзны нэлээн бас санаа зовоосон ийм асуудал болчхоод харагдаад байна л даа. Тэгээд хуулийн төслийн өөрийнх нь санхүүжилт талаас нь харахад жишээлбэл, хуулийн төсөл дээр бол тэр мэдээллийн сантай холбоотойгоор 45.3.15 дээр “хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгуулах” гэж заачихсан байгаа юм. Тэгсэн мөртөө 47 дугаар зүйлийг уншаад үз дээ та нар. 47.1 дээр “мэдээллийн санг бүрдүүлэхэд улсын төсвөөс 1 удаа санхүүжүүлэх бөгөөд цаашид нийгмийн ажилтны холбоо хариуцна” гээд. 1 хууль дотор 2 хоорондоо зөрчилдсөн юм ороод ирчихсэн байна шүү нөхөд өө. Тэгэхээр энийг бас жоохон анхаарах, өөрөөр хэлбэл энэ хуулиа чамбайруулах шаардлагатай байна л гэж би хэлэх гээд байгаа юм л даа. Ялангуяа Нийгмийн халамжийн тухай хууль, Мэргэжлийн холбооны тухай хуультай давхацсан заалтууд юу юм бэ. Яах юм бэ. Тэгээд жишээлбэл 37 дугаар зүйлийг харъя. Нийгмийн ажилтны нийтлэг эрх үүрэг гэдэг дотор 37.1.3 дээр “нийгмийн ажилтны эрх, хууль ёсны сонирхлоо хамгаалуулахаар эвлэлдэн нэгдэх” гээд байж байгаа. Энэ чинь үйлдвэрчний эвлэлийн хууль дээр байгаа шүү дээ. Төрийн албаныхаа тухай хууль дээр бол үйлчилгээний ажилтнуудыг бол эвлэлдэн нэгдэх эрхийг нь өгчихсөн байгаа. Тэгэхээр зэрэг бусад хуулиуд дээр байгаа заалтуудыг бүгдийг нь зүгээр 1, 1-ээр нь аваад жишээлбэл 37.1.4 “төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзах” энэ чинь Төрийн албаны хууль дээрээ байдаг шүү дээ. Байдаг ойлголт. Тэгэхээр ийм ингээд давхацсан заалтууд нэлээн байна шүү гэдгийг хэлье.

Тэгээд хамгийн гол нь жишээлбэл танилцуулгыг сонсож байхад 3000 гаруй нийгмийн ажилтан Монгол Улсад байгаагаас 978 бараг, 980 бараг 1000 гэж ойлгож болно. Сургуулийн байгууллагад ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл боловсролын сургалтын байгууллагад. Ингээд 1/3 нь ингээд ажиллаж байх үед энэ хуулийн Боловсролын ерөнхий тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл дээр энэ хуульд заасан нийгмийн ажилтны нийтлэг эрх, үүрэг, эрх зүйн баталгаа Нийгмийн ажлын тухай хуульд заасны дагуу зохицуулна гээд энэ хууль руу татаад аваад ирж байгаа юм. Ингээд татаад аваад иртэл энэ хуульд яах юм бэ гэсэн чинь хариуцлагыг нь 2 янз болгоод, эхнийх нь ажил олгогчийн өмнө .../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэлт 1 минут.

П.Наранбаяр: Тэгээд энэ дээрээ нөгөө ажил олгогчийнхоо өмнө хариуцлагыг мэргэжлийн үйл ажиллагааны хариуцлага хүлээнэ гэж байгаа юм. Тэгчхэнгүүтээ ёс зүйн хариуцлагаа мэргэжлийн холбооны өмнө хүлээнэ. Энэ уг нь бол ойлгож байна. Салбарын нэгдсэн удирдлагаар хангана. Уялдааг хангана гэдгийг ойлгож байна. Гэхдээ ажил олгогч энийг яаж хүлээж авах вэ. Ёс зүйн хариуцлага өөрийнх нь өмнө хүлээхгүй. Дээр нь нэмээд тэр мэргэжлийн холбоонд заавал элсэж ороод, тэгээд гишүүнчлэлийн татвараа өгнө. Тэгэхээрээ багш хүн бол нийгмийн ажилтан хүн бол үйлдвэрчний эвлэлийн татвараа өгч байгаа, дээр нь нэмээд ингээд өгдөг ийм болж

эхлэх ийм юм байгаад байна. Тэгэхээр хууль бичилт талаас нь уялдуулах талаас нь бас энэ ажлын хэсэг байгуулагдаад хийвэл сайн ажиллаасай гэж би хүсэж байна.

Тэгээд бас энэ материал боловсруулж оруулж ирж байгаа энэ албан тушаалтнууд анхаараач ээ. Жишээлбэл сая өгсөн материал дээрээ тэр 6 дээр 31,4 тэрбум гэж байсан нийт төсвийн зарлага Монгол Улс. Үгүй ээ, юу яриад байгаа юм. Энэ чинь тийм биш шүү дээ. Тэгэхээр энэ алдаануудаа бас засаарай. Юун долларын ханш бичээд явчхав.

П.Ганзориг: Хууль санаачлагчаас хариулж байя. Тэгээд энэ төсөв тооцоотой холбоотой асуудал дээр, Засгийн газрын гаргасан дүгнэлт тооцоон дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир сайд орж ирээд бас хариултаа өгөөд явах нь зөв. Энэ бас зөрүүтэй тоонууд байгаа юм байна лээ. Тэгээд өнөөдөр анхны хэлэлцүүлэг явж байгаа учраас энэ асуудлуудаа бол тодорхой болгох нь зөв. Ингээд хууль санаачлагч Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Наранбаяр гишүүнд баярлалаа. Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Яг зөв. Та нөгөө төсвийн тооцооллыг бас харсан байна. Эхлээд бид нар жил хагасын өмнө хуулийн төслийн Гэр бүлийн яаман дээр боловсруулагдаж ирсэн төслийг яг аваад тэгээд 1 жил хагасын өмнө бол Засгийн газар луу явуулж, санал авсан байгаа. Энэ санал дээр дэмжихгүй байгаа гэдэг 1 үндэслэл нь бол зардлын асуудал байсан. Тэгэхээр энэ зардлын асуудал дээр бид нар дахиж хараад, тэр зардлыг анх хийсэн тооцоо нь анх нийгмийн ажлын төслийг эхлүүлэх хэрэгжүүлэхтэй холбоотой анхны зардлын тооцоон дээр шинэчилж энийг хийсэн гэсэн үг. Тэгэхээр энэ суурин дээр энэ 106 тэрбум гээд тооцооллууд ерөөсөө огт ингээд анхныхаараа жоохон алдаатай ийм тооцоо байсан учраас бид нар Засгийн газраас ирсэн саналын дагуу зардлын тооцоог шинэчилж хийгээд яг энэ мэдээллийн сантай холбоотой болон 2 талт үндэсний холбоо байгуулах зардлыг нь авч үлдээд, бусдыг нь бол огт оруулаагүй. Шинэчилж байгаа гэсэн үг.

Техникийн засваруудыг бол маш сайн ойлгож байна. Энэ дээр бас манай хуулийн шинжээч маань ажлын хэсгээс нэмж хариултуудыг бас өгье.

П.Ганзориг: 1 номер нэмэлтээр хариулъя. Ажлын хэсгээс.

Г.Оюунболд: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөл маань 2, 3 удаа өөрчлөгдсөн байгаа. Эхлээд төрийн захиргааны төв байгууллагын боловсруулж байсан. Тэгээд ахиж 2 дахь удаа боловсруулагдаад лиценз болон бусад зүйлүүд ажлын хэсэг дээр ингээд хасагдсан байгаа. Яагаад гэвэл ихэнх нь төрийн албан хаагч нийгмийн ажилтнууд байдаг юм байна. Тэгэхээр лицензлүүлчихээр төрийн алба ажиллах энэ эрхэд халдах ийм боломж үүсчээд байгаа учраас тэрийг хассан байгаа. Тэгээд ийм учраас хойшоогоо зарим нэг техник болон таны хэлж байгаа 1, 2 давхардлууд үлдсэн байна. Яалт ч үгүй. Тэгэхээр тэр дээр цаашид анхаараад явъя.

Бусад тэр нөгөө зардалтай холбоотой зүйлийг бид нар зардлын тооцоог ахиж хийсэн байгаа. Тэгэхээр тэр дээр бол мэдээллийн сан дээр 950, холбоог 1 удаа анхны удаа мэргэжлийн холбоо байгуулахад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр 120 сая гээд.../минут дуусав/

П.Ганзориг: Наранбаяр гишүүн тодруулах уу. Наранбаяр гишүүн тодруулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ дээр бас ингээд түүхий байгаа зүйлийг нь энэ дээрээ ний нуугүй ярьчихсан нь дээр шүү дээ. Тийм ээ. Гэхдээ би зарчмын хувьд дэмжээд байгаа шүү. Үнэхээрийн энэ салбар дундын энэ асуудлыг шууд шийдэж байгаа мэргэжлийн ийм удирдлагаар хангаж байгаа явдал энэ Зулпхар гишүүний хэлээд байгаа, Саранчулуун гишүүн ингээд танилцуулаад байгааг бол дэмжээд байгаа юм. Тэгэхээр энэ Монголд бас шинэ ийм юу үүсэж байна гэж ийм эрх зүйн бас ийм харилцааг бий болгож байгаа хууль гэж харж байна.

Гэхдээ одоо жишээлбэл тэр 37.2.10 дээр “хууль тогтоомжид заасан тохиолдолд нийгмийн ажилтны холбооны гишүүнчлэлийн хураамжийг төлөх” гээд бүр яг ингээд маш хүчтэй заагаад хаячихсан. Одоо ингээд л үйлдвэрчний эвлэлийн татвараа төлөөд, нийгмийн ажилтан бол холбооныхоо татварыг заавал төлнө гээд ингээд ороод ирж байгаа юм.

Дээр нь нэмээд 39.1.4-ийг хар даа. Хориглосон зүйл заалт дээр хувийн давуу байдлыг ашиглах харилцаа тогтоохыг бас хориглоод хаячихсан. Үгүй ээ, харилцаа тогтоох гэж юуг хэлээд байгаа юм. Зүй бус харилцааг тогтоохыг хэлж байгаа байлгүй дээ гэж ойлгоод. Тэгэхээр бичилт талаас нь онцгой анхаарахгүй бол ер нь энэ .../минут дуусав/

П.Ганзориг: Энэ түрүүчийн асуусан асуултад нөгөө зардал төсвийн тооцоотой холбоотой асуулт байгаа. Тэгээд сайд нь байхгүй, орж ирэхгүй байгаа юм байна. Тэгэхээр энэ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас төлөөлөл хэн байна. 7 номер дээр Учрал байна уу. Учрал тэр зардлынх нь тооцоон дээр тодорхой хариулт өгье. 7 номер.

С.Учрал: Гишүүн Наранбаяр таны асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөл хариулж байна. Хуулийн төслийн хамгийн анхны хувилбар дээр буюу эмхэтгэл дээр суусан байгаа төсөв бол саяын Саранчулуун гишүүний хэлсэнчлэн засагдсан байгаа.

Тэгээд бид нар дахиж ажиллаад зөвхөн мэргэжлийн холбоо байгуулах болон мэдээллийн нэгдсэн сангийн уялдуулсан энэ интеграцыг хийх төсвийг авч үлдсэн. Нийтдээ 920 сая төгрөгийн зардал улсын төсөвт тусахаар байгаа. Хуулийн төслийг боловсруулж байх үед одоо ажиллаж байгаа 3100 нийгмийн ажилтнуудыг 5100 болгож 2000 орчим нийгмийн ажилтнаар нэмж байж бид нар олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, яг нормативаар ажиллах боломжтой юм байна гэсэн анхны төсвийн хувилбарыг боловсруулсан тооцоолол эмхэтгэл дээр суусан байна. Таны хэлж байгаачлан бид нар санхүүгийн тооцоолол дээрээ дахиад тооцоолол хийгээд тэгээд .../минут дуусав/

П.Ганзориг: Боловсролын яамнаас хариулж байя. Тэгээд тэр хооронд энэ Засгийн газрыг яг төлөөлж байгаа нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байгаа. Дуудуулж байна. Тэгэхээр 8 номер Цогзолмаа Боловсролын яамнаас хариулъя.

М.Цогзолмаа: Улсын Их Хурлын гишүүн Наранбаярын асуултад хариулъя. Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга Цогзолмаа. Ер нь бол нийгмийн ажилтны хүрээний асуудлууд бол мэдээж Боловсролын ерөнхий хуульд бас тодорхой зохицуулалтууд байдаг. Тухайлан хэлэхэд бол, нийгмийн ажилтнуудад боловсролын салбарын байгууллагын, сургалтын байгууллагын ажилтнуудад нөгөө нэмэгдэл олгох зохицуулалтууд, мөн

боловсролын салбарын удирдах болон бусад ажилтнуудын ёс зүйн асуудал энэ тэр бол яг холбогдох журмаараа боловсролын салбарт бол зохицуулагддаг. Өнөөдөр харин Нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолт бол байхгүй байгаа. Тэгээд энэ хууль батлагдсанаар бид нар бас энэ албан тушаалын тодорхойлолт бас оновчтой батлагдана гэж бас харж байгаа.

П.Ганзориг: Хууль санаачлагч Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Яг энэ нөгөө нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм гээд байдаг. Энэ бол олон улсын стандарт дээр заадаг нийгмийн ажлын үйлчилгээг хэн авдаг вэ гэхээр тусламж дэмжлэг шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийн хүн ам энэ үйлчилгээнд голдуу хамрагддаг. Нөгөө талдаа бас тодорхой цаг зуурын нөхцөл байдалд орсон, амьдралдаа ямар нэгэн шийдвэр гаргах шаардлагатай байгаа, тэгээд тэрийгээ нийгмийн халамж даатгалын одоо байгаа тогтолцооноос яаж авах аргаа мэдэхгүй байгаа хүмүүст ч гэсэн нийгмийн ажлын үйлчилгээ бас байдаг. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор хувь хүний эмзэг нарийн мэдээллүүд хувийн мэдээллүүдийг авдаг учраас нийгмийн ажлын олон улсын дүрэм дээр юу гэж заадаг вэ гэхээр үйлчлүүлж байгаа хүнтэйгээ хувийн харилцаа тогтоох, тэр мэдээллийг нь өөртөө давуу тал болгож ашиглахгүй байх тухай асуудал дүрэмд байдаг учраас энд ингэж 39.1.4 дээр тусгагдсан байгаа. Тэгэхдээ энийг томъёолол талаас нь явал энэ дээр зөв засаж сайжруулах эсэхийг нь бол ажлын хэсгийг ажлын хэсгийг өргөжүүлж бас засаж .../минут дуусав/

П.Ганзориг: Та нэмэлтээ аваад дахиад тодруулчихсан шүү дээ. Тэгээд Наранбаяр гишүүн бас саяынхаа тэр тооцоололтой холбоотой асуудлыг чуулган дээр асууж болно. Тэгээд шаардлагатай бол бас салбарынх нь сайдаас бичгээр тайлбар хүргүүлье. Тодруулга хүргүүлье. Бум-Очир гишүүн асуулт асууя.

Д.Бум-Очир: Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлмээр байна. Одоогоор бол үндсэндээ дэлхий дээр 15 орчим улс яг бие даасан хуультай байдаг юм байна. Тэгээд энийг та бүхэн мэдэж байгаа байх. Тэгээд анх бол энэ салбар аж үйлдвэрийн хувьсгалын дараа 19 дүгээр зуун, 20 дугаар зуунд бий болсон юм л даа. Тэгээд анх бол энэ буяны, сайн дурын байгууллага маягтай эхэлсэн. Тэгээд 20 дугаар зуунд бол үндсэндээ мэргэжлийн байгууллага, тусгай мэргэжилтэн болж хөгжсөн ийм түүхтэй. Аж үйлдвэрийн хувьсгалын дараа юу болсон бэ гэхээр ажилгүйдэл ядуурал, хүүхдийн хөдөлмөрийн асуудал, эрүүл мэндийн асуудал гээд маш олон хотжилтыг дагаад үүсдэг нийгмийн маш олон асуудлууд бий болсон. Энэ асуудлуудыг зохицуулах зорилгоор нийгмийн ажилтан гэдэг ийм мэргэжил бий болжээ гэдгийг хэлмээр байна.

Манайх ч гэсэн ялангуяа энэ зарчмаар явж байгаа. Ингээд сүүлдээ бол энэ нь тусгай мэргэжилтэн, тэгээд бие даасан хуультай байх шаардлага дэлхийн олон орнуудад бий болсны 1 нь манайх гэж би бол ойлгож байгаа. Энд олон мэргэжлийн хүмүүс сууж байна. Мэдэж байгаа болов уу гэж бодож байна.

Би бол ийм зүйл хэлчихмээр санагдаад байгаа юм. Бие даасан хуульгүй байхад яагаад байгаа юм бэ гэдэг асуултад бид нар хариулах ёстой байх. Тэгээд энэ хууль санаачлагчид маань бас ажлын хэсгийнхэн маань энийгээ бас сайхан тайлбарлаж гишүүдэд болоод олон нийтэд ойлгуулж өгөх нь зүйтэй. Зүгээр миний ойлгож байгаагаар бол түрүүн бас Аубакир сайдын танилцуулгад гарсан. Мэргэжлийн биш хүмүүс энэ мэргэжлийн ажлыг хийдэг энэ зүйл бол зогсоно. Зүгээр нийгмийн ажилтан гээд тэгэхээр хэнийг ч хамаагүй аваачаад тавьчихдаг, хэн ч хийж

болдог юм шиг. Энэ хүн багш биш ээ, сэтгүүлч биш ээ, сэтгэл зүйч биш ээ, нийгмийн халамжийн ажилтан бас биш ээ. Энэ хүн бол нийгмийн ажилтан. Тэгээд нийгмийн ажилтны ажлыг нийгмийн ажилтнаар нь хийлгэдэг болмоор байгаа юм.

Цаашлаад энэ бүхнээс нь үүсээд бас нэг том учир дутагдал бий болдог нь юу вэ гэхээр нийгмийн ажилтан гэдэг хүний ажил үүргийг ойлгодоггүй, үнэ цэнийг нь мэдэрдэггүй ийм нөхцөл байдлууд нийгэмд бас үүсдэг. Түүнчлэн нийгмийн ажилтны үйлчилгээний чанар тодорхой хэмжээгээр унадаг. Эрсдэлүүд үүсдэг. Мөн хариуцлагын механизм сул байдаг. Нийгмийн ажилтан гэдэг хүн чинь өөрийн мэргэжлээр үйлчилгээ үзүүлээд, хэрвээ тэр үйлчилгээ нь буруу үйлчилсэн бол эсвэл янз бүрийн болох, болохгүй юманд орооцолдсон бол хариуцлага тооцдог механизм байх ёстой. Өнөөдөр нийгмийн ажилтан биш хүнийг нийгмийн ажилтны орон тоон дээр авч ажиллуулчихаад бид нар тэр хүнээс ямар хариуцлага, ямар мэргэжлийн ур чадвар нэхээд суух вэ гэдэг ийм зүйл байгаа.

Дараагийн нэг маш чухал зүйл бол юу вэ гэхээр энэ маш олон салбар дундын асуудал байдаг. Сая Наранбаяр сайд яриад байна. Боловсролын салбар дээр ч юм уу. Тэгэхээр энэ хууль бол салбар хоорондын уялдаа холбоог бол маш сайжруулахад чиглэсэн ийм чухал зүйл гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр энэ бүх шалтгааныг хэлээд үзвэл бид бол магадгүй хуультай болох нь зүйтэй. Манай өнөөдөр ядуурал, эрсдэлт бүлэг ямар хэмжээнд байгаа билээ. Энийгээ үзвэл бид бие даасан хуультай байх .../минут дуусав/

П.Ганзориг: 1 минут нэмж авах уу. Хууль санаачлагч Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Баярлалаа.

П.Ганзориг: Бум-Очир гишүүн асууна шүү.

О.Саранчулуун: Уучлаарай. Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Хуульгүйгээр, Нийгмийн ажлын хуульгүйгээр 30-аад жил явлаа. Энэ үр дүнд бид нар халамжаас хөдөлмөрт концепц маань шинэчлэгдэж чадсангүй гэдэг 1 дүгээр шалтгаан байгаа. Хуульгүйгээр явсан бие даасан энэ эрх зүйн орчныг бүрдүүлээгүй явсны нэг хар гай гэдэг юм уу, сөрөг үр дагавар нь юу вэ гэхээр өнөөдөр нийгмийн ажлын мэргэжлээр сурч байгаа оюутнуудын тоо жилээс жилд буурч байна. 1 дэх үндэслэл нь.

2-т гэвэл нийгмийн ажлын орон тоон дээр ажиллаж байгаа хүмүүс дундаж ажиллах жил нь 3 жил буюу ажлаа солиод ингээд явчхаж байгаа. Тэгэхээр энэ зэрэг асуудлууд нь өөрөө эргээд манай нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний чанарыг дордуулахад тогтвортой биш байхад хүргэж байгаа. Энэ нь эргээд нөгөө үйлчилгээ авдаг иргэддээ ч гэсэн олигтойхон шиг үйлчилгээ авч чадахгүй байгаатай холбоотой. Тэгэхээр энэ нь том зургаараа бид нар ядуурлыг бууруулах, ажилтай болгох, бие даасан шийдвэр гаргадаг болох энэ тэр асуудлуудыг бол ерөөсөө энэ дээр шийдэж чадахгүй байгаа гээд асуудал.

Давхар энэ хуулийн нэг том өөрчлөлт гэдэг юм уу онцлог нь бид нар урьдчилан сэргийлэлтийн тогтолцоог бий болгох гээд байгаа юм. Одоо өнөөдөр байгаа түрүүний дурдсан 13 хууль, 20 гаруй журамд байгаа энэ 162 заалт дээр байгаа энэ олон маягтууд ихэвчлэн юунд хэрэглэгддэг вэ гэхлээр хариу арга хэмжээ байхгүй юу. Хүүхдийн хүчирхийлэл гарсан үед, хэрэг төвөг гарсан үед дараа нь яаж

зохицуулах вэ, ийм үед яах вэ гэдэг дээр л яваад байгаа. 4 салбарт бараг 20 гаруй ийм журам дүрэм байгаа гээд боддоо. Энэ дотор нь ингээд ухаад үзэх юм бол адилхан адилхан мэдээллүүд хоорондоо давтагдсаар л байгаа. Тэгэхдээ 1 үйлчилгээ авсан хүн дараа нь яах вэ гэдэг ийм залгамж ерөөсөө байхгүй байгаад байгаа байхгүй юу. Та нар хэрвээ санаж байгаа бол Жокер гээд кино байдаг юм шүү дээ Холливудын. Тэр кинон дээр байнгын 1 хүн сэтгэл зүйч дээр очоод ингээд яваад байдаг шүү дээ урт хугацаандаа. Тэгээд цаанаас нь мөнгө нь шийдэгдэхээ болинуут тэр хүний үйлчилгээ зогсдог. Тэр хүн эргээд байн байн очдог байсан нөгөө илааршил сэтгэл зүйн асуудлаа шийдэж зогсоогүй 1 шалтгаан нь нийгэмд тэр ануун байдлыг үүсгэдэг кино. Холливудын зөндөө кинон дээр байдаг. Нийгмийн ажилтан ирлээ гэхээр гэр орноо цэвэрлээд, хүүхдийнхээ яаж идэж уудгийг нь яриад, би ингэж хүүхдэдээ цаг гаргадаг гээд ярьдаг. Энэ бүх тогтолцоо энэ бүх тогтолцоо чинь урьдчилан сэргийлэлт байхгүй юу. Эрсдэлтэй байж магадгүй, шар гэрэл ассан хүмүүстээ бид нар анхаарч, илүү улаан болгохгүйн тулд ажилладаг тогтолцоо дээр нийгмийн ажилтнууд олон улсад хамгийн их үүргийг гүйцэтгэдэг юм.

Сая Бум-Очир гишүүн өөрөө хэлж байна. Тэгэхээр Монгол Улсад нийгмийн ажил бий болсон анхны шалтгаан нь бол хариу арга хэмжээний хэлбэртэй байхгүй юу. Тэр 162 заалтын чинь 80 гаруй хувь нь дандаа хариу арга хэмжээтэй байгаа. Гэхдээ өнөөдөр бид нар урьдчилан сэргийлэлт рүү орохгүй бол бид нар яг гал унтраадаг шиг ажилласаар байгаад халамжийн мөнгө, халамжийн тогтолцоо шинэчлэгдсэн ч юм байхгүй. Нийгмийн хамгааллын зардал нь буурсан ч юм байхгүй. Хөл дээрээ босож бие даасан иргэд нь байсан ч юм байхгүй ийм байдалд ороод байгаа учраас өнөөдөр зөвхөн Саранчулуун болон энэ гишүүдээс гэхээсээ илүү энэ салбарын 6 өөр холбоо, энэ салбар өөрсдөө ер нь энийг бие даасан хуулиар шийдэж байгаад ямар ч байсан мэргэжлийн үйлчилгээг нь зөв томьёолж өгөхөөс эхэлье. Тэгээд салбар дундын асуудлыг нь нэгтгэж цэгцэлье. Одоо байгаа нөөц дээрээ мэдээллийн санг бүрдүүлье гэдэг ийм агуулгатай хууль болгож оруулж ирж байгаа. Тэгээд мэргэжлийн холбоо бол одоо байгаа хамгийн боломжит зохион байгуулалт л юм билээ. Тэгэхээр энэ хуульд бас нэг зүйл нь мэргэжлийн холбоог нь эхлүүлж өгье гэдэг ийм л бүтэц байгаа. Тэгэхээр энэ бол бие даасан хуультай байх шалтгаануудад бол би тэргүүн хэсгүүдийг нь ингэж дурдаж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Бум-Очир гишүүн тодруулъя.

Д.Бум-Очир: Саранчулуун гишүүнд баярлалаа. Тэгээд миний гол хэлэх гээд байгаа санаа бол энэ хуулийн ач холбогдлыг л илүү их ярьж ойлгуулах гэсэн л санаа шүү. Би та бүхэнтэй адилхан бодолтой байгаа. Нэг зүйл ийм тоо байдаг юм уу, үгүй юу. Би бас сонсмоор байна л даа. Монгол Улсад 3 сая 500, 600 мянган хүн байна гэхэд нийгмийн ажилтны үйлчилгээ авах хэрэгцээ шаардлагатай хэчнээн хүмүүс байдаг юм бэ. Хүн амын 30 орчим хувь нь ядууралтай байгаа гэж үзвэл тэр бүлэгт л лав ажиллах байх. Сургууль, цэцэрлэгүүд дээр ажиллах байх. Ингээд үзвэл би ямар нэг ойлголт төрүүлэх гээд байна вэ гэхээр 3 сая 600 мянга орчим хүний чинь магадгүй тэд орчим хувь нь энэ нийгмийн ажилтны үйлчилгээ шаардлагатай байна шүү дээ гэдэг зүйлийг яривал магадгүй энэ хуулийн ач холбогдол бас их өргөн хүрээтэй юм байна гэж ойлгогдох болов уу гэдэг үүднээс ийм тоо байдаг болов уу гэж асууж байгаа хэрэг л дээ. Яг заавал тоо байх албагүй байх. Тэгэхдээ байвал сонирхолтой байна.

П.Ганзориг: Ажлын хэсгээс 7 номер Учрал хариулъя.

С.Учрал: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Манай Монгол Улсад бол 2,2 сая орчим иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, даатгал аваад явж байгаа. Аубакир сайдын хэлсэнчлэн ер нь бол олон улсын нормативаар бол 1500 иргэн тутамд 1 нийгмийн ажилтан ажиллах ийм нормыг олон улсын жишгээр тогтоосон. Тэгэхээр бид нар ер нь нийгмийн ажилтны норм нормативыг олон улсын жишиг тогтоохдоо яадаг вэ гэхээр 1 дүгээрт хүн амын тоотой нь харьцуулдаг, 2 дугаарт эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа гэр бүлийн тоо, ахмад настны тоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо, мөн асаргаа халамж зайлшгүй шаардлагатай иргэдийн тоо гээд мөн дээрээс нь гэмт хэрэг гаралт зөрчлийн тоотой харьцуулдаг. Ингээд ер нь 7 шалгуур үзүүлэлтийг минимал шалгуур үзүүлэлт болгоод зөвшөөрсөн тоо нь бол норматив нь бол 1500 иргэн тутамд 1 нийгмийн ажилтан гэдэг. Тэгэхлээр манай Монгол Улсад бол .../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж хариулах уу. 7 номер гүйцээж хариулъя.

С.Учрал: Тэгэхлээр манай улсад бол хамгийн багадаа 2200 нийгмийн ажилтан тогтвортой буюу зайлшгүй ажиллах шаардлагатай. Мөн үүн дээрээ нэмээд урт хугацааны туршид нөхөн сэргээх үйлчилгээ авах шаардлагатай иргэдийн тоотой харьцуулаад үзэх юм бол дээрээс нь нэмээд мөн тооны нийгмийн ажилтан байдаг. Ойролцоогоор 5000-6000 нийгмийн ажилтан зайлшгүй ажиллах шаардлагатай гэсэн норматив бид нар тооцоолол хийсэн байдаг.

П.Ганзориг: Хууль санаачлагч нэмж хариулъя.

О.Саранчулуун: Одоо байгаа нийгмийн ажил нь ялангуяа боловсролын салбар дээр жишээлбэл нийгмийн ажилтны хэрэгцээ олон төрлөөр байгаа. Өнөөдөр сургууль дээр 1 нийгмийн ажилтан манай стандартаар бол 1500 гэж байгаа байхгүй юу. Гэтэл зарим орон нутагт 2000-3000 хүүхдийн дунд жишээлбэл нийгмийн ажилтан нөгөө сумын төвийн хүн амаас болоод байгаа. Нөгөө талд өнөөдөр 6 настай хүүхэд дотуур байранд амьдарч байгаа. Ээж ааваасаа хол. Гэтэл дотуур байранд өнөөдөр нийгмийн ажилтан байхгүй байгаад байгаа. Бид нар бол сэтгэл зүйчийн тухай ярих бол бүр дараагийн асуудал болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ мэтчилэн бид нарт хүний хэрэгцээ байгаа. Тэгэхдээ энэ бол хэний тухай ярьж байна гэхээр 4 жилийн турш бакалавраар сураад, мэргэжлийн жинхэнэ нөгөө мөрөөдлөөр ярьдаг болбол лицензтэй нийгмийн ажилтны тоог бид нар ярьж байгаа байхгүй юу. Гэтэл өнөөдөр төрд ажиллаж байгаа нийт нийгмийн ажилтнуудын маань 60 гаруй хувь нь өөр мэргэжлээр сурсан. Бид тэд нарыг буруутгахгүй. Тэгэхдээ тэн дээр чинь яалт ч үгүй өөр мэргэжил учраас ур чадварын хэрэгцээ гараад байгаа байхгүй юу. Тэгэхээр маш их хэрэгцээтэй байгаа учраас эрх зүйн орчныг нь дэмжиж байж л бид нар энэ элсэлтийг авч, энэ хүмүүсийн .../минут дуусав/

П.Ганзориг: Энхнасан гишүүн асууя.

Л.Энхнасан: Баярлалаа. Энэ нийгмийн ажлын тухай хуулийг зарчмын хувьд бол дэмжээд байгаа. Яагаад гэвэл одоо байгаа тогтолцоог нь уялдуулах, эрсдэлийг эрт илрүүлэх кэйс удирдлагыг тодорхой болгох тийм зорилготой юм болов уу гэж бодож байгаа. Харин би бас яг энэ хуулийг манай ХҮН намын зөвлөлөөр танилцуулагдаагүй учраас дөнгөж танилцаж байна л даа. Тэгээд эхний байдлаар ингээд харахаар техникийн нэлээн их сайжруулалт хэрэгтэй юм байна. Ялангуяа одоо жишээлбэл, нийгмийн ажлын үйлчилгээ гээд 2 дугаар бүлгийн 12 дугаар зүйлд

нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх талаар биччихсэн байгаа. Тэгэхээр нийгмийн ажилтан бол анхан шатын дэмжлэг үзүүлэх, үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд анхан шатын сэтгэл зүйн тусламж бол үзүүлэх ёстой. Тэрийг илрүүлэх ёстой. Харин энэ нийгмийн сэтгэл зүйн зөвлөгөө чинь бол нийгмийн ажилтан тэгээд сэтгэл зүйч хоёулаа хамаарах ийм үйлчилгээ байхгүй юу. Энэ тусдаа бас байх ёстой. Гэтэл энэ 12.2 дээр болохоор нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөний хэлбэрээр үзүүлнэ гэгчихсэн байгаа юм. Тэгэхээр нийгмийн ажилтан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлээд, ингээд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхээр энд ойлгогдож байна л даа. Тэгэхээр энэ заалтыг илүү тодорхой болгоод сайжруулахгүй бол бас ойлгомжгүй зүйл байна шүү.

Тэгээд ер нь өчигдөр бас Боловсролын яаманд очиход сэтгэл зүйч гээд 499 хүн сургуульд ажиллаж байгаа байхгүй юу. Сэтгэл зүйчийн, тэгээд нийгмийн ажилтны энэ ажлын байрны тодорхойлолтыг яг тодорхой болгохгүй бол нийгмийн ажилтан сэтгэл зүйч хийгээд байдаг, сэтгэл зүйч нь бас нийгмийн ажил хийгээд байдаг ийм бас давхардсан юм харагдаад байна лээ шүү. Тэгээд уг нь Аубакир сайдаас асуух гэж байсан юм. Энэ хууль чинь ерөөсөө нийгмийн халамжийн тухай хуультай, Боловсролын ерөнхий хуультай бол маш нягт холбоотой байгаа байхгүй юу. Тэгээд өнгөрсөн 2 жилд Нийгмийн халамжийн хуулийн шинэчилсэн найруулга орж ирнэ гээд одоо хүртэл орж ирээгүй байгаа. Энэ юу болсон бэ. Ямар шатад явж байна. Энэ хуультай ер нь Нийгмийн ажлын хууль нийцэж байгаа юу.

П.Ганзориг: Хууль санаачлагч хариулья. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Энхнасан гишүүний санал маш чухал. Ялангуяа боловсролын салбарт өнөөдөр бид нар нэг бол сэтгэл зүйч, нэг бол нийгмийн ажилтан байлгая гэдэг энэ асуудал яригдаж байгаа. Эрүүл мэндийн салбарт болохоор нэг бол эрүүл мэндийн нийгмийн ажилтан, нэг бол нийгмийн эрүүл мэндийн ажилтан гэдэг юм явагдаад байгаа. Энэ дээр та хэд хэрвээ анзаарах юм бол энэ чинь өөр мэргэжлийн зарим төрлийн үйл ажиллагаатай давхцах агуулгатай байгаад байна. Яг сайн харах юм бол сэтгэл зүйн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл зүйн эмчилгээ гэдэг зүйлүүд нь арай жоохон агуулгын, утгын хувьд арай өөр асуудлууд байгаа.

Дэмжих бүлэг гэдэг нэг ийм функц байгаад байгаа. Энэ жишээ авъя л даа. Энэ Чинбүрэн дарга байхад бид нар хамт хөхний хавдраар өвдсөн эмэгтэйчүүдэд дэмжих бүлгээр 7 хоногт 3 удаа уулзаад, хөхний хавдрын дараа өөрийнхөө сэтгэл зүйн сэтгэл хөдлөлөө яаж барих вэ, яаж хооллох вэ, гэр бүлийнхэнтэйгээ яаж харилцах вэ гэдэг энэ сэтгэл зүйн тулгамдсан асуудал дээр чиглэсэн зөвлөмж, зөвлөгөөнүүдийг нийгмийн ажилтан өгдөг. Харин сэтгэцийн өвчин эмгэг болоод ирэх юм бол сэтгэцийн нөгөө психиатор эмгэг шинж рүү ороод ирэх юм бол энэ дээр эрүүл мэндийн асуудал яригдаж байгаа гэсэн үг. Сэтгэл зүйн гэмтэл гэдэг нэг юм бас яригдаад байгаа. Сэтгэл зүйн онош үүсээд. Энэ дээр бол мэргэжлийн сэтгэл зүйч ажиллана. Тэгэхээр хэдий чинээ нөгөө сэтгэл зүйн асуудлын хэв шинж болон гүн гүнзгий байдал ихсэх тусам энэ дээр зардал өсөөд байгаа гэсэн үг. Зардал өсөж байна. Илүү ганцаарчилсан үйлчилгээ шаардагдаж эхэлдэг. Тэгэхээр нийгмийн ажилтан бол тэр түвшин рүү нь орохгүйгээр илүү бүлгээр ажиллах, ганцаарчилсан энгийн сэтгэл зүйн асуудлуудыг ялангуяа харилцааны шинжтэй асуудлууд, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх шинжтэй асуудлууд, өөрийгөө хүнд ойлгуулах асуудал, хүнтэй ойлголцох асуудал гээд энэ шинж дээр бол нийгмийн ажилтан маш их оролцоотой байдаг. Энийгээ нөгөө олон улсад байдаг лицензтэй нийгмийн ажилтнууд дээр бүүр нарийсдаг байхгүй юу. Mental health буюу сэтгэцийн эмгэгийн

салбарт нийгмийн ажилтнууд яаж ажилдаг вэ гээд бүүр сургагдаж ингэж явдаг. Тэгэхээр таны хэлж байгаачлан бид нар энийг боловсролын салбарт ялгаж салгах хэрэгтэй. Ажлын байран дээр. Энэ хууль дээр байгаа 6-18 дугаар зүйл дээр тусгагдсан тэр шууд үйлчилгээ дээр бид нар ялгаж тодорхойлно. Нөгөө талд зэрэгцээд бид нар сэтгэл зүйчийнхээ ажлын байрны тодорхойлолт, үүргийг бас ялгаж тодорхойлж салгах хэрэгтэй.

Харин эрүүл мэндийн салбарт бид нар нийгмийн эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн нийгмийн ажилтныхаа ажлын байрыг нийгмийн эрүүл мэндээсээ салгаж авах хэрэгтэй байгаа. Тэгэхгүй бол тэд нар маань био статистик хийж байна, тархвар зүй хийж байна. Холилдоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ л хамгийн гол хуулийн бас нэг онцлог зохицуулалт нь байгаад байгаа.

Түрүүний нэмэлтээр тэр нөгөө Нийгмийн халамжийн тухай хууль бусад хуультай уялдаа, холбоотой асуудлаар бол бичгээр эсвэл гэр бүлийн яамнаас холбогдох яамнаас нь хариулт авбал зүгээр байх гэж бодож байна.

П.Ганзориг: Тэр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга орж ирнэ гээд 2 жил болж байгаа гээд тэгж байна. Тэгээд энэ дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас төлөөлөл нь хариулах уу. Учрал хариулах уу. 7 номер.

С.Учрал: Энхнасан гишүүний асуултад тодруулга хэлье. Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл нь бол бэлэн болсон. Сая Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой үзэл баримтлалыг дахин батлуулаад, Засгийн газраас, яамнуудаас санал аваад бэлтгэх ажил хийгдэж байгаа. Манай яаман дээр. Баярлалаа.

П.Ганзориг: Энхнасан гишүүн тодруулъя.

Л.Энхнасан: Тэгээд төсөл нь бэлэн болчихсон гээд 2 жил ярьж байна шүү дээ. Яг энэ хууль маань танай тэр төсөлтэй чинь шинэчилсэн найруулгатай нийцэж байгаа юм уу, үгүй юм уу гээд би яг тодорхой асууж байгаа шүү дээ.

Тэгээд ер нь нөгөө түрүүний сэтгэл зүйн нөгөө салбарыг сэтгэцийн болон сэтгэл зүйн салбарын гээд ярихаар нөгөө хууль нь ер нь шинэчлэх шаардлагатай болчихсон юм байна лээ. Сэтгэцийн эрүүл мэндийн хууль 13 жилийн өмнө батлагдсан хууль байгаа. Тэгээд тэнд сэтгэл зүйн салбарын болон нэр томьёо, салбарын төрөөс ямар бодлого хэрэгжүүлэх вэ гэсэн юм ерөөсөө байхгүй. Тэгэхээр энэ хуулийг би бас шинэчилж найруулах ажлыг өөрөө бас хариуцаж ажиллая гэж бодож байгаа. Энийг ч гэсэн бас эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд тэгээд ер нь эрүүл мэндийн салбарын бас 1 нийгмийн эрүүл мэндийн том асуудал гэж үзэж байгаа учраас энэ дээр бас анхаарна уу гэж хүсэж байна.

П.Ганзориг: Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Бүрэн дэмжиж байна. Харин анхааруулж бас хэлэх хэдэн санаануудаа зориуд бүр хэлье гэж бодож байгаа. Ялангуяа дэмжигдээд ажлын хэсэг байгуулагдах юм бол бид юун дээр илүү анхаарч төвлөрч ажиллахаа бас зориуд анхаарах ёстой. Тэгэхээр бид өнөөдөр 1 салбарын тухай биш, хүний амьдралын чанар, нийгмийн шударга байдал, эрүүл мэндийн үр дүнг хамтад нь сайжруулах системийн өөрчлөлтийн тухай энэ хууль яригдана гэж ойлгож байна.

Нийгмийн ажил бол ядуурал, хүчирхийлэл, архаг өвчин, сэтгэл зүйн асуудлаар зэрэг олон хүчин зүйл огтлолцдог тэр цэг дээр ажилладаг. Тиймээс энэ хууль бол зөвхөн нийгмийн хамгааллын биш, эрүүл мэнд, боловсрол, хууль зүй, санхүүгийн салбарын уялдааг бий болгох ёстой. Тийм учраас ажлын хэсэгт оруулахдаа бид бүүр анхнаас нь зөвхөн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагуудаас гадна Сангийн яам, хууль, боловсрол бүгд энд уялдаж ажиллах ёстой. 5 зүйлийг би бас зориуд анхааруулж хэлмээр санагдаж байна.

1 дүгээрт, эрүүл мэндийн нийгмийн ажлыг хуульчлах. Түрүүн Саранчулуун гишүүн хэллээ. Маш их чухал зүйлийн ялгааг гаргаж хэллээ. Эмнэлэг бүрд нийгмийн ажилтны үүрэг, оролцоо тодорхой болох хэрэгтэй. Ялангуяа хавдар, архаг өвчний үед эмчилгээ дангаар хангалтгүй. Нийгмийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Эмчилгээний үр дүнг хэн хариуцах юм. Эмчилгээний дараах нийгмийн бодлого өөрөө их чухал.

2 дугаарт кэйс менежментийн тогтолцоо гэж бид бас яриад байгаа. Энийг бас анхаараарай. 1 иргэн, 1 гэр бүл болон олон байгууллагаар явж төөрч болохгүй. Харин 1 цэгээс удирдлагатай үйлчилгээ авах системийг энэ хуульд суулгах ёстойг бүр анхаараарай.

3 дугаарт нийгмийн ажилтны мэргэжлийн стандарт лицензийг ярьж байгаад их баярлалаа. Саранчулуун гишүүн ээ, чадвар, ёс зүй, хариуцлагыг тодорхой болгож үйлчилгээний чанар дээшилнэ. Тэгэхээр стандарттай болох асуудал дээр бол 100 хувь санал нэг байна.

4 дүгээрт санхүүжилтийн бодит механизмыг бид оруулахгүй бол хууль гараад байдаг, хэрэгждэггүй. Сайн хууль бичихээс илүү хэрэгжих боломжтой санхүүжилтийн тогтолцоог хамтад нь шийдэх нь чухал. Тийм учраас Сангийн яамны оролцоог эхнээс нь бий болгох ёстой. Тэгээд дараа нь тийм ч мөнгө байхгүй, ийм ч юм байхгүй. Энийг нь батлахгүй, тэрийг батлахгүй гэдэг яриа байж болохгүй.

5 дугаарт салбар хоорондын уялдаа. Эрүүл мэнд, боловсрол, хууль зүй, нийгмийн хамгааллын байгууллагуудын мэдээлэл үйлчилгээ уялдах энэ хуульд чухал үр дүнтэй. Тийм учраас ажлын хэсэг байгуулбал Байнгын хорооны дарга та энэ дээр бүр онцгой анхаарч, мэргэжлийн ийм баг байгуулах дээр онцгой анхаараарай.

Тэгэхээр би бол энийг дүгнэж хэлэх гээд байгаа юм. Саранчулуун гишүүнд би зориуд баярлалаа гэж хэлье. Энэ хууль батлагдсанаар бид асуудлыг дараа нь засах биш эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх гэдэг үг хэллээ.

2-т иргэний системийн хооронд гээхгүй байх энэ чухал юм байхгүй юу. Өдөр болгон энэ халамж авах шаардлагатай болж байгаа улсуудыг бид гээдэг юм шүү. Тэгээд системийн хооронд хаягддаг. Нийгмийн эмзэг бүлгийг бодитоор хамгаалах суурийг тавина гэж харж байгаа. Тийм учраас их чухал зүйл. Бүгдээрээ хамтраад, ажлын хэсгээрээ улам сайжруулж, энэ амьдралд хэрэгжих .../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэх үү. Санал байна тийм ээ. Галбадрах гишүүн асуулт асууя.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд хүргэе. Би бас хууль санаачлагчдын нэг байгаа. Тийм учраас асуулт асуухгүй, үг хэлье гэж бодож байна. Энэ бол яг цагаа олсон бас

хууль. Дэмжиж байгаа. Гишүүд бас хэлж байна. Энд нэгдсэн эрх зүйн орчин бас бүрдүүлж байгаа гэдгээрээ их онцлогтой байна. Өмнө нь бол тус тусдаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Эрүүл мэндийн яам гээд тус тусдаа Хууль зүйн яам гээд ингээд тус тусдаа хуулиуд байсныг энд бас нэгтгэж оруулж ирж байгаагаараа онцлогтой байна. Тэгээд хууль санаачлагчийн танилцуулсан сая 1 стандарт, 1 хууль, эрх зүйн орчинтой байлгая гэж байгаа нь маш ач холбогдолтой гэж үзэж байна. Тэгээд миний хувьд бол яах вэ, боловсролын салбарын хүний хувьд тэр 978 сургуулийн нийгмийн ажилтан байдаг гэсэн ийм тоо хэлж байна.

Тэгэхээр энэ хүмүүсийг сургуулийн нийгмийн ажилтны асуудлыг бид бүүр илүү нарийн агуулга талаас нь сургуульд бол багш нар гэж байна. Физикийн багш байна. Физикийн багш маань ингээд 4 жилд бэлтгэгдээд гарахад нөгөө заах агуулга, хөтөлбөр юм нь их ойлгомжтой, тэр чиглэлээрээ бэлтгэгдээд ингээд гарч ирдэг. Нийгмийн ажилтан гэдэг маань өөрөө шинэ байгаа. Би олон сургуулийг тойроод явдаг. Тэгээд сургуулийн бодлогод бол их чухал байгаа. Сургууль чинь бол зөвхөн мэдлэг олгодог шинжлэх ухааны мэдлэг олгоод л ингээд гаргаад байдаг ийм асуудал бол байж болохгүй. Бид нар цогцоор нь хөтөлбөрөө авч үзэх ёстой. Цогцоор нь гэдэг дотор бол төлөвшлийн бодлогыг авч үзэх ёстой. Хуучин бол хүмүүжлийн эрхлэгч нар гэж байдаг шиг энэ нийгмийн ажилтнууд бол тийм үүрэг гүйцэтгэж байгаа. Тэгээд зарим гарч ирсэн нийгмийн ажилтнуудтай ярилцаад ингээд байж байхад хүүхэд хамгаалал ч гэдэг юм уу эсвэл зөвхөн 1 талаа барьдаг. Хүүхэд хөгжил ч гэдэг юм уу, 1 талаа бариад байгаа. Тэгэхээр нийгмийн ажилтан сургуулийн нийгмийн ажилтан гэдэг бол сургуулийн удирдах ажилтан байх ёстой. Сургуульд захирал байна. Тэгээд сургалтын бодлогыг барьдаг сургалтын менежер байгаа бол тэр төлөвшил хандлага хүмүүжлийн асуудлыг барьдаг нийгмийн ажилтнууд байна. Тэгээд энэ талаас нь тэр их, дээд сургуульд бэлтгээд гаргаж байгаа хөтөлбөр нь тэгээд буцаад сургууль дээр ирээд ажиллах ажлынх нь агуулгатай нөгөө сургууль дээр, ЕБС дээр заадаг хичээлийн агуулгатай дээд сургуулийнх нь хөтөлбөр нь уялдаж байдаг гэдэг талаас нь ингээд цогцоор нь авч үзэх. Түүнээс биш нэг асуудлыг нь ингээд барьж үзэхгүй байх тал дээр нь бид нар бас боловсролын байгууллагуудтай ингэж хамтарч нэгдэж байх ёстой байна гэдэг тал дээр би тэр салбар хоорондын уялдаа, хөтөлбөрийн уялдаа, тэгээд энэ дээр бас хуулийн онцлог нь мэргэжлийн холбоог их тодорхой гаргаж өгч байгаа нь их сайшаалтай хууль болж байгаа гэдгийг хэлэх байна.

П.Ганзориг: Үг хэллээ. Түрүүн Чинбүрэн гишүүн бас маш чухал саналууд хэлсэн. Галбадрах гишүүн бас чухал саналууд хэлж байна. Энэ дээр бол ялангуяа энэ салбар хооронд болон дундын уялдааг хангах дээр анхаарч, Байнгын хороо дээр бас буцаад ажлын хэсэг байгуулагдах үед яамдын оролцоог хангах дээр Байнгын хорооны хувьд анхаарч ажиллана гэдгээ хэлье. Одоо гишүүд асуултууд асууж дуусаад, дараа нь санал хэлээд, тэгээд санал хураалтууд явагдана. Хуулийн төсөл болон хамт мэдүүлсэн хуулийн төсөл тус бүрээр явуулах учраас гишүүд бас энэ танхимдаа орж ирэхийг урьж байна. Ингээд Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ хуулийн төслийн талаар бас нэмж мэдээлэл авах, сайн ярилцах зүйл байгаа юм болов уу гэж ингэж харж байна. Сургууль, салбаруудад бас нийгмийн ажилтнууд байгаа. Эрүүл мэндийн салбар ч гэдэг юм уу, боловсролын салбар сургууль гээд. Түүнээс гадна хорооны нийгмийн ажилтан гэж бас байгаа. Суман дээр болохоор зөвхөн сумын Тамгын газарт нийгмийн ажилтан гэж байгаа. Бүтэн сум хариуцсан. Түүнээс биш хөдөө сум дээр бол сумын баг дээр нийгмийн ажилтан гэж байхгүй. Тийм учраас энэ сая их чухал

нөгөө салбар дундын уялдаа холбоо гэж ярьж байна. Яг үүнтэй адилхан нутаг дэвсгэрийн бас асуудлыг бас сайн бодож үзэх шаардлага байна уу гэж ингэж харж байна. Тэгэхгүй бол миний ойлгож байгаагаар энэ хуулийн батлагдсанаар бол Нийгмийн ажилтны ийм мэргэжлийн холбоотой болох гээд байх шиг байна.

Мэдээж нөгөө төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх гээд энэ төрийн чухал бодлогын нэг хэсэг нь энэ мөн л дөө. Гэхдээ энэ дотор чинь боловсролын салбарын нийгмийн ажилтнууд эрүүл мэндийн салбарын нийгмийн ажилтнууд, баг, хорооны нийгмийн ажилтнууд, сумын Тамгын газрын нийгмийн ажилтнууд ч гэдэг юм уу ингээд тус тусдаа харьяалагдаж байгаа ийм бүтэц бүрэлдэхүүнтэй хүмүүс учраас эд нар чинь яг нэгдэж нийлж, нэг дээвэр доор, нэг холбоонд харьяалагдаж чадах уу. Энэ чинь бүр цаашаа задраад одоо юу гэдэг юм, Боловсролын салбарын нийгмийн ажилтны холбоо, баг хорооны нийгмийн ажилтны холбоо гээд ингээд явчихгүй юу. Тэгэхээр энийг ер нь яаж харж байгаа юм бэ гэдэг дээр бас хариулт хэлээч.

Тэгээд ер нь цаашдаа миний бодож явдаг зүйл бол 1 хуулийн төсөл санаачлаад л төсөв дээр баахан зардал нэмээд, тэгээд намар болоод төсөв батлах болохоороо төсвөө буулгаач гээд л орилцгоогоод унадаг шүү дээ. Тэгэхээр энэ төсөв дээр зардал нэмэхгүй ачаалал нэмэхгүй байх тал дээр бас ямар боломж байгаа юм бэ гэж ийм 1, 2 үндсэн асуултад хариулт хэлээч.

П.Ганзориг: Хууль санаачлагчаас хариулах уу. Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Нийгмийн ажлын мэргэжлийн холбоод бид нар 20 жилийн өмнө анх МУБИС дээр Английн школоор нийгмийн ажлын хөтөлбөрүүдийг боловсруулаад явж байсан. МУИС болохоор Герман школоор нийгмийн ажлуудыг бас нэлээн зааж ингэж явсан. Тэндээс салбарлаад манай анагаах дээр болон нийгмийн ажлынхан ингээд нэг тэнхим байгуулагдаад явсан. ШУТИС бас нийгмийн ажлын тэнхимтэй. Тэгэхээр энэ тэнхим буюу анхны нөгөө нийгмийн ажлын пионерууд маань өөр өөрийн төрөлжсөн ийм холбоодыг байгуулсан байгаа. Одоогоор 6 төрлийн холбоо байгаа. Энэ холбоодынхоо дотор нь гишүүд нь хэн байдаг вэ гэхээр тухайн салбараар ажиллаж байгаа нийгмийн ажилтнууд буюу илүү төгсөгчид маань байгаад байгаа гэсэн үг. Тэгэхээр салбар бүрийн төгсөгчид бие даасан өөрсдийн холбоотой. Тэрнээс өмнө бид нар нийгмийн ажлын багш, сурагчдын холбоо гэдэг ийм бас байгууллага байдаг. Тэндээ энэ бусад холбоо нь нийлээд бид нар тэр мэргэжлийн удирдлагаар хангах сургалт, хичээл заадаг бол хичээлийнхээ хөтөлбөрийг сайжруулах зэрэг олон асуудлууд дээр хамтарч ажилладаг байсан. Тэгэхээр одоо ингэж хэлбэл нэг их хилсдэхгүй байх. Бусад салбар мэргэжлүүдийг бодвол манай нийгмийн ажилтнууд буюу одоо байгаа энэ мэргэжлийнхэн маань харьцангуй бие биетэйгээ уялдаа холбоо сайтай. Нэгдсэн холбоондоо энэ холбоод нь өөрсдөө салбар гишүүд болж орохоор ийм зохицуулалтыг бас хоорондоо ярьсан байгаа.

Мөн энэ хуулийн төслийг боловсруулах санаачлах явцад тус холбоодын саналууд бас оролцож, төлөөллүүд нь бас оролцож боловсруулалцсан гэсэн үг. Тэгэхээр энэ тал дээр бол санаа зовох зүйл бол бага байх. Таны хэлсэн төсөв гэдэг дээр эхний удаад бид нар ер нь бол яах вэ, нийгмийн ажил гэдэг бол түрүүн Энхнасан гишүүн бас хэлж байсан. Сэтгэл зүйн үйлчилгээтэй юугаараа ялгаатай, юугаараа өөр юм бэ гээд байгаа. Тэгэхээр сэтгэл зүйн асуудал, сэтгэл зүйн өвчин 2-ыг бид нар ялгаж харах хэрэгтэй. Тэгэхээр нийгмийн ажилтнууд жишээлбэл сэтгэл зүйн асуудалтай хүмүүст үйлчилгээ үзүүлэхэд жишээлбэл ажлын байрных нь тэр

өрөө тасалгаа, хувийн орон зайнууд хэрэгтэй байгаа. Тиймэрхүү, ажлын орчин, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан зүйлүүд дээр тухайн төрийн байгууллага өөрсдөө энэ хуульд тодорхойлогдсоны дагуу орчин нөхцөлийг нь бүрдүүлэх үүргийг хүлээж байгаа ийм бүтэц л байгаа юм. Одоо энэ хуулийн төсвөөс гарч ирж байгаа гол зардал нь юундаа байгаа вэ гэхээр 4, 5 салбар дундын одоо байгаа нийгэм, хүн ам зүйн мэдээлэл өгөгдлийг цэгцлэх, хооронд нь шилжих тогтолцоог нь мэдээллийг нь цэгцлэх ийм зардлууд бас тусгагдаж байгаа. Тэгээд тэр зардал нь бодсоноос харьцангуй бас багаар тусгаж байгаа. Тэгэхээр энэ дээр бас манай Цахим яамнаас бас хүмүүс оролцож байгаа. Төлөөллүүд. Энэ дээр бас шийдлүүд байгаа. Тэгээд эхний ээлжид хоорондоо системийг нь уяад одоо хийгдэж байгаа зарим системтэй уялдуулчих юм бол бид нар үйлчлүүлэгч иргэн дээр үүсэж байгаа ачаалал, зардлыг нэг талдаа бас бууруулж байгаа ийм үр ашигтай байгаа. Тэгэхээр энэ дээр бас нэмж ажлын хэсгээс тайлбарыг бас би сонсоосой гэж хүсэж байна.

Тэгээд бусад саналыг бол ялангуяа хороо, халамжийн асуудал дээр бид нар аймаг болгоны нийгмийн ажилтнуудтай онлайнаар нэг бүрчлэн хуулиа танилцуулаад тойроод бас явж байгаа. Тэгэхээр энэ дээр бас ирсэн саналуудыг ажлын хэсгийн хүрээнд бас нэмж сайжруулна. Баярлалаа.

П.Ганзориг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. 1 номерын микрофон.

Г.Оюунболд: Түрүүн таны асуусан чинь тэр салбар бүрд ингээд нийгмийн ажилтнуудын судалгааг бид ингээд гаргасан байгаа. Ихэнх нь төрийн байгууллагад ажилладаг гээд баг хорооны, халамжийн, тэгээд хүүхэд хамгааллын гэх мэт ийм олон салбарын нийгмийн ажилтнууд байгаа. Энэ хүмүүсийн хувьд мэргэжлийн хувьд нэгдэн нийлэх ийм бүрэн боломжтой. Жишээ нь, би бол өөрөө хуульчдын холбооны гишүүн. 7000 хуульчид энэ холбоонд харьяалагдаад, 12 салбар ажиллаж байсан ч гэсэн үл хамаараад энэ холбоондоо нэгдээд ажиллаад ирсэн. 10 жил болж байгаа ийм зохицуулалт байгаа юм. Тэгэхээр нийгмийн ажилтны хувьд бол мэргэжлийнхээ хувьд нэгдэн нийлэх тал дээр бол гайгүй асуудал багатай байна гэж бид нар урьдчилсан байдлаар холбоодтой санал солилцсон байгаа.

Төсвийн хувьд бол энэ жилдээ эхний гараан дээр ингээд 1 тэрбум бас хэтрэхээргүй зардлын тооцоог ахиж шинэчилж гаргасан байгаа. Өөрөөр хэлбэл мэдээллийн сан, холбоог байгуулах .../минут дуусав/

П.Ганзориг: Хосбаяр гишүүн тодруулах уу. Гишүүд асуулт асууж дууслаа.

Ингээд хуулийн төсөл санаачилсан илтгэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Болормаа гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүн орсон юм байна. Зулпхар гишүүн асуулт үг хэлье.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ дахин амар амгаланг айлтгая. Та бүхэн маш чухал үнэтэй саналууд хэлж байна. Энэ хуулийн төсөл өөрөө анхдагч хууль учраас салбар дундын бас тодорхой асуудлуудыг уялдуулах зайлшгүй шаардлагатай ийм зохицуулалтууд их яваад байгаа юм. Тэгээд тэрэнтэй холбоотой та бүхний асуусан асуултаас эргээд төрийн албан хаагчдын ялангуяа төрийн үйлчилгээний албан хаагчдын эвлэлдэн нэгдэх эрх, зарим тохиолдолд бас улс төрийн эрх нь ч гэсэн явж байгаа иймэрхүү нарийн ширийн зүйлүүд байгаа. Гэхдээ энийг бол одоо байгаа эрх зүйн орчинтойгоо уялдуулж зохицуулахгүй бол эргээд бас дараа нь асуудал үүсэх ийм нөхцөл байдал үүснэ гэж угаасаа ажлын хэсэг дээр бас ярьж байсан. Яг энийг та бүхэн олж харж ярьж байна.

Нөгөөтээгүүр үйлчилгээтэй холбоотой зүйлүүд их нарийн зохицуулалтуудтай, стандарттай, журмуудтай юм. Тэр болгоныг бас энд оруулж болохгүй байсан зүйлүүд байсан. Болох уу, үгүй юу гэдэг бас эргэлзээ байсан. Тэр эргэлзээг бас та бүхэнд тайлах байдлаар асуултууд асууж байна. Тэгэхээр эндээс маш сайн бид ярьж байгаад ажлын хэсгээ байгуулах ёстой юм байна. Тэр ажлын хэсэг дээр энэ талуудын оролцоог бүрэн хангах ёстой юм байна. Энэ төрийн бус байгууллага нь өөрөө оролцох ёстой. Мэргэжлийн холбоо нь ямар нэгэн байдлаар байгаа шүү дээ.

Нөгөөтээгүүр энэ үйлчилгээг үзүүлж байгаа нийгмийн ажилтнууд өөрсдөө бас төлөөллөө оролцуулсан байдалтай байвал их зөв юм байна. Холбогдох төрийн байгууллагууд нь гэсэн үг шүү дээ. Цаашлаад энэ дээр бас гишүүд дотроос энэ асуудлаар бас туршлагатай, мэргэшсэн гишүүд байгаа. Гишүүд маань өөрсдөө ороод ингээд явбал энэ хуулийг бид чамбайруулаад аваад явах бүрэн боломжтой гэж ойлгож байна. Ингээд хэлэлцэх эсэхийг нь дэмжчихээд, яг ажлын хэсэг дээр бол энэ нарийн зүйлүүдээ бүгдийг нь яриад явсан нь дээр байх.

Сая Эрхтэн, эд, эс шилжүүлэх тухай хууль дээр ч гэсэн яг тийм юм боллоо шүү дээ. Анхдагч хууль учраас бидний хувьд бол маш их ярих зүйл бас зарим зүйлийн нарийн судлах зүйлүүд гарсан. Тэгээд ажлын хэсэг дээр энийг бол нарийвчлан судлаад бүр зарчмын зөрүүтэй бараг 70 орчим санал хураагдаад ингээд явсан. Яг үүнтэй адилхан манай Байнгын хорооноос гарах бодлогын түвшинд их томоохон бас шийдэл байх үүднээс энэ хуулийг тал талаас нь та бүхэн бас дэмжээд, мэргэжлийн түвшинд нь бас саналаа хэлээд ингээд аваад яваач гэсэн ийм хүсэлтэй байна. Баярлалаа.

П.Ганзориг: Болормаа гишүүн үг хэлнэ байна.

Х.Болормаа: Эрхэм гишүүддээ мөн ажлын хэсгийн хамт олондоо энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны өмнө Нийгмийн ажлын тухай хуулийн анхдагч төслийг санаачлан боловсруулаад өргөн мэдүүлж байгаа Саранчулуун гишүүн болон бусад Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Монгол Улсад нийгмийн ажилтан хэмээх энэ мэргэжилтнүүд сургууль, эмнэлэг, халамж, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл мөн тэгээд хороо, сум зэрэг олон салбарт ажиллаж ирсэн байгаа. Гэвч тэдний мэргэжлийн нэгдсэн статус, стандарт, карьерын тогтолцоо өнөөдрийг хүртэл бол хангалтгүй байгааг та бүхэн бүгдээрээ бас мэдэж байгаа гэж бодож байна.

Энэхүү хуулийн төсөл нь нийгмийн, ажлын, мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, салбар хоорондын уялдаатай, чанартай хүртээмжийг үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх зорилготой чухал хуулийн төсөл гэж бол миний хувьд үзэж байна. Нийгмийн ажил бол зөвхөн халамж тараах ажил биш юм. Энэ бол гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэнийг хамгаалах, хүүхдийг эрсдэлээс хамгаалах, аврах өндөр эрсдэлтэй өрхтэй ажиллах, хүнийг хэвийн амьдралд эргэн оруулах мэргэжлийн үйлчилгээ байдаг. Өнөөдөр Монголын нийгэмд маш олон сэтгэл түгшээсэн олон хэрэг, эмзэг асуудлууд бол гарч байна. Ийм үед энэ хууль бол урьдчилан сэргийлэх, хамгаалах, сэргээн засах кэйс менежментийн тогтолцоог бэхжүүлэх ийм чухал хууль болох нь гэж харж байна.

Би бас яг энэ хуулийг дэмжиж байгаа онцлог, үг хэлж байгаа утга учир нь манай нийгэмд тулгамдаад байгаа олон асуудлын нэг болсон гэр бүлийн хүчирхийллийн асуудалд онцгой анхаарч ажиллаж, санаа тавьж байна. Энэ хүрээнд хууль, эрх зүйн

орчинд үнэлгээ хийх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, гадаадын сайн туршлагыг нэвтрүүлэх, бодлогын түвшнийг шинэ шатад гаргах чиглэлээр цогц үйл ажиллагааг эхлүүлээд явж байна.

Тийм учраас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлд нийгмийн ажилтны үүрэг кэйс менежмент хамгааллын үйлчилгээний асуудлыг тодорхой тусгах чиглэлээр төсөл санаачлагч нартай хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж байна.

Ингээд Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд бол дэмжиж байгаагаа илэрхийлж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Гишүүд үг хэлж дууслаа. Хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Бейсен гишүүн, Бум-Очир гишүүн, Галбадрах гишүүн, Ганхүлэг гишүүн санал хураалтдаа бэлтгэе. Түвшин гишүүн, Энхтуяа гишүүн, Эрдэнэбат гишүүн. Санал хураалтдаа орьё.

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 22 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 77 хувиар санал дэмжигдлээ.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж 77 хувиар санал дэмжигдлээ. Нийтдээ 8 дагалдах хуулиар санал хураана.

Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хурааа. Санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 63 хувиар дэмжигдлээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хурааа. Санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, санал 77 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 72,7 хувиар дэмжигдлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, санал 77,3 хувиар дэмжигдлээ.

Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, санал 77,3 хувиар дэмжигдлээ.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, санал 77,3 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 72,7 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг төсөл тус бүрээр санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Хөххүүгийн Болормаа уншиж танилцуулна.

Ингээд хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хурал өндөрлөснийг мэдэгдье. Хууль санаачлагчид болон ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлье.

16.17 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ